



ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Соёл урлагийн их сургуулийн
Радио телевиз, медиа урлагийн сургууль

Сургалтын хөтөлбөрийн нэр: ЗУРАГ АВАЛТ

Индекс: (021101)

Шинжээчийн баг:

Ахлагч: Р.Чанцалдулам

Гишүүд: Д.Чулуунгэрэл

Г.Түвдэндорж

Он сар өдөр: 2018 . 05 .10

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	Error! Bookmark not defined.
I. Магадлан шинжлэх үйл явц, төлөвлөлт	4
II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга	5
III. Мэргэжлийн зөвлөлийн тодорхойлолт.....	Error! Bookmark not defined.
IV. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт	6
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	7
Шалгуур 2. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	11
Шалгуур 3. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	18
Шалгуур 4. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	26
Шалгуур 5. Багшийн үйл ажиллагаа	32
Шалгуур 6. Сургалтын үйл ажиллагаа	39
Шалгуур 7. Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө	43
Шалгуур 8. Чанарын үнэлгээ, баталгаажилт.....	47
V. Оролцогчдын нэрс	50
I. Ярилцлагад оролцсон багш нарын нэрс	50
II. Ярилцлагад оролцсон Оюутны нэрс.....	50
III. Ярилцлагад оролцсон Ажил олгогчийн нэрс	51
IV. Ярилцлагад оролцсон төгсөгчдийн нэрс	51
VI. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал	5152
VII. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр.....	Error! Bookmark not defined.

I. Магадлан шинжлэх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Соёл урлагийн их сургуулийн Радио телевиз, медиа урлагийн сургууль	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Зураг авалт	
Индекс	021101	
Шинжээчид	Ахлагчийн нэр, ажил, албан тушаал: Р.Чанцалдулам/ХААИС-ийн бакалаврын хөтөлбөрийн эрхлэгч, Ph.D/ Гишүүдийн нэр, ажил, албан тушаал: Д.Чулуунгэрэл/ШУА-ийн философийн хүрээлэн реферант, Ph.D/ Г.Түвдэндорж /Боловсрол телевизийн ерөнхий инженер/	
БМИҮЗ-ийн зохицуулагч	Зохицуулагчийн нэр, албан тушаал: Б.Мядагмаа – Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хариуцсан ахлах менежер/	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд
	2018.04.25-30	Тайлангийн материалтай уншиж танилцсан.
	2018.05.11	Баасан гариг
	09 ⁰⁰ -10 ⁰⁰	Зохицуулагч шинжээчийн багийг танилцуулна
	10 ⁰⁰ -12 ⁰⁰	Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой танилцах
	12 ⁰⁰ -13 ⁰⁰	Сургуультай танилцах аялал
	13 ⁰⁰ -14 ⁰⁰	Цайны завсарлага
	14 ⁰⁰ -15 ⁰⁰	Оюутнуудтай хийх уулзалт
	15 ⁰⁰ -16 ⁰⁰	Төгсөгчидтэй хийх уулзалт
	16 ⁰⁰ -17 ⁰⁰	Номын сан, лаборатори, анги танхим болон бусад үйлчилгээний хэсэгтэй танилцах
	2018.05.12	Бямба гариг
	09 ⁰⁰ -10 ⁰⁰	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах
	10 ⁰⁰ -11 ⁰⁰	Төгсөгчидтэй уулзах
	11 ⁰⁰ -13 ⁰⁰	Нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах
	14 ⁰⁰ -17 ⁰⁰	Шинжээчид урьдчилсан дүгнэлтээ хэлэлцэж гаргана.
	17 ⁰⁰ -18 ⁰⁰	Шинжээчийн баг магадлан итгэмжлэлийн урьдчилсан дүгнэлтийн хөтөлбөрийн багт танилцуулж, зарим зөвлөгөөг өгнө

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Тус хөтөлбөр нь 1996 оны 05 дугаар сарын 6-ны өдөр Радио телевизийн хэрэг эрхлэх газрын даргын А/110 тоот тушаалаар Монголын Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын харьяа уран бүтээлийн болон техникийн боловсон хүчин бэлтгэх зорилгоор анх дээд мэргэжилтэй мэргэжилтэн бэлтгэх гараагаа эхэлсэн. Зураг авалтын хөтөлбөрөөр сүүлийн таван жилд нийт өдрийн ангид 551 оюутан, эчнээ ангид 64 оюутан суралцаж байна. Зураг авалт хөтөлбөрөөр бакалаврын зэрэг эзэмшсэнээр киноны зураглаач, телевизийн болон баримтат киноны зураглаач, мэргэжлийн гэрэл зурагчин, гэрлийн мастер, кино телевизийн продюсер зэрэг чиглэлээр мэргэших боломжтой. Уг хөтөлбөрөөр 1996 оноос хойш 320 гаруй бакалаврын зэрэгтэй мэргэжлийн зураглаачдыг төгсгөсөн.

Хөтөлбөрийн сургалт нь дадлага давамгайлсан, төсөл, уран бүтээл-үйлдвэрлэлд суурилсан бөгөөд сургалтын төлөвлөгөөний бүтэц нь ерөнхий суурийн хичээл нь 37 кр буюу 28.9 хувь Мэргэжлийн хичээлүүд нь 32 кр буюу 25.0 хувь, Мэргэшүүлэх хичээлүүд нь 59 кр буюу 46.0 хувиас илүүгүй байна.

IV. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Тус хөтөлбөр нь оюутан сурагчдын суралцах нөхцөл, тав тухтай байдлыг хангахаас гадна сургалтын хөтөлбөрийн агуулгыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн тасралтгүй хөгжүүлж байна. Зураг авалт хөтөлбөр нь дадлага, төсөл, уран бүтээлийн үйлдвэрлэлд суурилсан үзэл баримтлалтай. Төгсөгчийн загвараа салбарын болоод улс орны хөгжилд хувь нэмэр оруулахуйц мэдлэг, ур чадвартай, нийгэмд эерэг нөлөө үзүүлэхүйц ёс зүйтэй, зах зээлд өрсөлдөх, хөрвөх чадварыг эзэмшсэн байхаар тодорхойлон амжилттай хэрэгжүүлж байна. Төгсөгчдийн 70-80 орчим хувь нь ажлын байраар хангагддаг. Тухайлбал, сүүлийн таван жилд 121 зураглаач төгссөн ба 96 нь буюу 79 хувь нь мэргэжлийн байгууллагад зураглаач мэргэжлээр ажиллаж байна. Төгсөгчид нь төгсөөд 1-2 сарын дотор ажилд ордог бөгөөд зарим төгсөгч нь төгсөхөөс өмнө ажлын байраа олж чаддаг нь тухайн хөтөлбөрийн эрэлт сайн байгааг тодорхойлж байна. Мөн түүнчлэн ажил олгогчид нь төгсөгчдийн мэдлэг, мэргэжлийн ур чадварт “онц сайн” дүнг өгдөг болох нь судалгаа, уулзалт ярилцлагаас харагдаж байна.

Зураг авалт хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг тус сургуулийн захирал/Д.Одсүрэн/, Сургалтын албаны дарга/Г.Баатар/, Ц.Цэвэлсүрэн/тэнхмийн эрхлэгч/, тэнхимийн багш /Г.Оюунчимэг/ Тэнхимийн лаборант /Г.Отгонтуяа/, сургуулийн нягтлан/Ж.Замбага/ нар бичсэн байна. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлангийн хувьд өмнөх үг, үндсэн 8 шалгуур, шалгуур бүрд SWOT шинжилгээ хийгдсэн байна.

ШАЛГУУР 1. ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1 Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Үзүүлэлт нотолгоо:

- ***Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийсэн байдал:***

Хөдөлмөрийн зах зээл, мэргэжлийн эрэлт хэрэгцээ, мэргэжилтэнд шаардагдах ур чадварын талаарх тандан судалгааг хийж ажилладаг нь сайшаалтай. Монгол улсын хэмжээнд нийт 88 телевиз, 75 кабелийн суваг үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрт шинэ залуу чадварлаг боловсон хүчин хэрэгцээтэй байгаа нь судалгааны үр дүнгээс харагдсан. Тухайлбал, төгсөгчдийг ажиллуулж байгаа 83 ажил олгогчоос сэтгэл ханамжийн судалгааг 2 удаа авч, үр дүнгээр нь хөтөлбөрөөр төгсөгчийн загвар, эзэмших шаардлагатай мэдлэг, ур чадварыг тодорхойлсон. Ажил олгогчид, төгсөгчдийн судалгаанаас харахад сүүлийн таван жилд 121 төгсөгчид төгссөн байгаагийн 79 хувь нь мэргэжлээрээ ажиллаж байгаа, төгсөөд 1-2 сарын дотор ажилдаа, зарим төгсөгч нь төгсөхөөс өмнө ажлын байраа олж чаддаг нь тухайн хөтөлбөр нь хөдөлмөрийн зах зээлд эрэлт хэрэгцээтэй байгааг илэрхийлж байна. Ажил олгогчид нь төгсөгчдийн мэдлэг, мэргэжлийн ур чадварт “онц сайн” дүнг өгдөг болох нь судалгаа, уулзалт ярилцлагаас харагдаж байна. Судалгааг асуулгын болон ярилцлагын аргаар авсан нь хөтөлбөрийг сайжруулах, төгсөгчийн загварыг гаргахад чухал ач холбогдолтой болсон тухай хөтөлбөрийн багш нарын уулзалтаар онцлон дурьдаж байлаа.

- Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй телевизүүдийн судалгааг хийсэн
- Зураглаач мэргэшлийн тандан судалгаа /судалгааны материал, нэгтгэл
- Ажил олгогчийн тандан судалгаа/судалгааны материал, нэгтгэл /
- Төгсөгчийн тандан судалгаа /судалгааны материал, нэгтгэл /
- Төгсөгчийн сэтгэл ханамжийн судалгааг тус тус хийсэн байна.

Төгсөгчийн /мэргэжилтний/ загвар



Төгсөгч мэргэжилтэний загварыг тодорхойлохдоо ажил олгогчид болон нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн гаргасан бөгөөд энэ нь мэргэжлийн ур чадвар, бүтээлч үйлдвэрлэл, амьдрах чадвар дээр тулгуурласан таван нийтлэг мэдлэг, ур чадвар эзэмшсэн төгсөгч байхаар тодорхойлсон байна. Үүнд: Мэргэжлийн ур чадвар, Техник технологийн ур чадвар, Бүтээлч сэтгэлгээ, Багаар ажиллах чадвар, Аналитик чадвар.

- **Хөтөлбөрийг индексийн хувьд ижил салбар, чиглэлийн гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан байдал /ялгаатай, давуу, сул тал, сайжруулалт/**

Ижил мэргэжлийн олон улсын нэр хүнд бүхий 3 хүртэлх их дээд сургуультай харьцуулан судласан нь хөтөлбөрөөр төгсөгчийн мэдлэг, ур чадварыг олон улсын түвшинд гарахад санаа тавьж ажиллаж байна. Дэлхийн нэр хүнтэй кино урлагийн 3 их дээд сургуультай харьцуулан судалж давуу болон дутагдалтай талуудыг олж харсан байна. Үүнд: *Full Sail university Los Angeles Film School, Columbia College Hollywood.*

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн эрэлт хэрэгцээг тодорхойлох оролцогч талуудаас 5 төрлийн судалгааг хийсэн. /Судалгааны үр дүн бүхий тайлан/
- ОХУ-ын Бүх Оросын кино урлагийн дээд сургуулийн зураглаач мэргэжлийн сургалтын төлөвлөгөөг үндэслэж байсан бол сүүлийн жилүүдэд бусад олон улсын нэр хүндтэй ижил мэргэжлийн хөтөлбөрүүдтэй харьцуулан судалж, тэдгээрийн хөтөлбөрийн агуулга, технологи, сургалтын заах арга зүй, багшийн ур чадвар, сургалтын орчин зэрэгт харьцуулан дүгнэлж хийж дахин сайжруулалтыг тасралтгүй хийсэн байна. /Ижил мэргэжлийн хөтөлбөрүүдтэй хийсэн судалгаа/

Зөвлөмж:

- Оролцогч талуудаас авсан судалгаанд үндэслэн хөтөлбөрөө хэрхэн дахин сайжруулалт хийсэн тухай нотлох баримт байхгүй байгаад анхаарч ажиллах;

1.2 Хөтөлбөрийн үзэл баримтлал, зорилго

Хөтөлбөрийн үзэл баримтлал тодорхой; төгсөгчийн эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлага нь мэргэжлийн салбарын хөгжил, зах зээлийн эрэлтэд нийцсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Үзүүлэлт нотолгоо:

- *Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримталж байгаа үзэл баримтлал, сургалтын арга зүй, тогтсон үнэлгээний систем*

Уг хөтөлбөр нь сургалтын дадлага давамгайлсан төсөл, уран бүтээл-үйлдвэрлэлд суурилсан үзэл баримтлалтай. Зураг авалтын сургалтын хөтөлбөрөөр суралцагч нь суралцах хугацаанд 5кр цагийн дадлага хийдэг байна. Хөтөлбөр нь ерөнхий суурь 37 кр, (28 %), Мэргэжлийн суурь 32 кр, (23%), Мэргэжлийн хичээл 49 кр,(41%), Дадлага(танилцах дадлага, үйлдвэрлэлийн дадлага-1, 2 гэж байна) 5 кр (4 %), төгсөлтийн ажил 5 кр, (4 %) тус тус эзлэж байна. СУИС-ийн бакалаврын хөтөлбөрийн журмын 6.1 “Оюутны мэдлэгийг үнэлэх” журмыг баримтлан ажилладаг. Үнэлгээг өгөхдөө багш 70 хүртэл оноогоор, улирлын шалгалтыг 30 хүртэл оноогоор тус тус үнэлүүлнэ. Хичээлийн үр дүнг үнэлэхдээ ирц-10 хувь, бие даалтууд-15 хувь, лабораторийн ажил-15 хувь, явцын сорил-1,2- 30 хувь, улирлын шалгалт-30 хувь байхаар дүгнэдэг байна.

- *Хөтөлбөрийн хүрэх үр дүн, онцлог, сургуулийн эрхэм зорилго, зорилттой нийцсэн байдал:*

Хөтөлбөрийн зорилго нь хөтөлбөрөөс гарах үр дүнтэй холбогдсон төдийгүй сургуулийн эрхэм зорилго, зорилтуудтай нийцэж, дэлхийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулдаг болох нь нотлогдсон.

- *Сургалтын арга зүй*

Хичээлийг удирдан явуулах сургалтын арга зүй нь дадлага, практикт суурилсан төсөл, бүтээл хийх цогц ур чадвар олгоход чиглэгдсэн заах арга, хэлбэрийг ашигладаг төдийгүй мэргэжлийн хичээл бүр багаар ажиллах, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэгдэж, орчин үеийн техник төхөөрөмж дээр ажиллуулдаг нь сайшаалтай харагдаж байна.

- *Төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлоход оролцогч, сонирхогч талуудын саналыг тусгаж, хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт төлөөллийг оролцуулсан байдал*

Хөтөлбөрөөр төгсөгчийн ур чадварыг тодорхойлохдоо ажил олгогч, төгсөгчдийн оролцоог хангаж, тэдэнтэй судалгаа, уулзалт ярилцлагыг удаа дараа хийсэн нь хичээлүүдийн агуулгын давхардлыг арилгаж, хөтөлбөрөөр төгсөгчийн эзэмших мэдлэг ур чадварыг тодорхойлоход ихээхэн ач холбогдолтой болсон байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн үзэл баримтлал орчин үеийн сургалтын үзэл баримтлалтай нийцсэн дадлага, үйлдвэрлэл, үр дүнд суурилсан хөтөлбөрийг хөгжүүлж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1.3 Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга; сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй; сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тогтмол тусган сайжруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо: Хөтөлбөрийг БСШУСЯ-ны А/174 тоот тушаалаар батлагдсан “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-ын дагуу боловсруулж СУИС-ийн эрдмийн зөвлөлийн 2014 оны 07 дүгээр сарын 4-ний өдрийн хурлаар хэлэлцэж баталсан. Мөн түүнчлэн хөтөлбөрийн оролцогч талуудын оролцоог ажил олгогч 30 хувь, төгсөгч 10 хувь, оюутан 10 хувь багш 25 хувь, мэргэжлийн байгууллага 25 гэсэн бүтэцтэйгээр нэмэгдүүлэн судалгаа, уулзалт, агуулгын шинжилгээний үр дүнд хэд хэдэн өөрчлөлтүүдийг хийж, хөтөлбөрийн дахин шинэчлэн 2016 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн захирлын тушаалаар батлуулсан байна. Хөтөлбөрийн удирдлага нь хөтөлбөрийн дэд хороо, Ерөнхий хороо гэсэн бүтэц зохион байгуулалттай ажилладаг. Хөтөлбөрийн үнэлгээг Uniculture удирдлага мэдээллийн системээр авах боломжтой бөгөөд хөтөлбөрөөр төгсөгч, ажил олгогчийг оролцуулдаг талаарх эх материалууд, мэдээллийн системийн бүрэн ажиллагааг шалгахад доголдолгүй ажиллаж байна.

Сургалтын төлөвлөлт нь онол, практикийг зохистой хослуулсан, суралцагчийн мэргэжлийн болон хувь хүний ур чадваруудыг хөгжүүлэхэд чиглэгдсэн байдал

- Сургалтын төлөвлөгөөг хөдөлмөрийн зах зээл, ажил олгогч, төгсөгчидтэй хийсэн судалгааны үр дүнд хичээл, агуулгын давхардлыг арилгах замаар нийт 2014, 2016 онуудад тус тус шинэчилсэнээр хөтөлбөрт эзлэх ерөнхий суурийн хичээл 28 хувь, мэргэжлийн суурь 23 хувь, мэргэжлийн хичээлүүд нь 45 хувь болсон ба дадлага 4 хувийг эзлэж байна.
- Хөтөлбөрийн хичээлийн заах арга зүй нь төсөл, дадлагад суурилсан арга барилыг түлхүү хэрэглэж онол, практикийн мэдлэг ур чадварыг аль алиныг нь өгөхөөр чиглэгдсэн байна. Нийт хичээлийн 55 хувь онол, 45 хувь практик мэдлэг ур чадвар өгөхөд чиглэсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хичээлийг удирдан явуулах технологийн хувьд оюутанд онолын мэдлэг, ур чадвар олгохоос гадна хандлага, хувь хүний ур чадваруудыг хөгжүүлэхэд чиглэж байна. Багш нар нь хамтарсан сургалтыг явуулдаг бөгөөд онол, практик хосолсон, сургалт, үнэлгээг хамтад ил тод хийдэг бөгөөд хичээлээр дамжуулан мэргэжлийн

холбогдолтой төсөл боловсруулах, оюутнууддаа мэргэжлийн цогц мэдлэг, ур чадварыг өгөх үүднээс бусад мэргэжлийн оюутнуудтай хамтад нь төсөлд ажиллуулах ингэснээр оюутнуудын багаар ажиллах, харилцааны ур чадварыг нэмэгдүүлэхэд их дөхөм болдог.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ШАЛГУУР 2. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, ТЕХНОЛОГИЙН НӨХЦӨЛ


2.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Эрүүл, аюулгүй, тохилог бие даан ажиллах орчинг бүрдүүлсэн байдал


Оюутан, багш нарын ажиллаж, амрах орчинг сайн бүрдүүлсэн. Дотоод засал сайтай, булан тохой бүрийг зөв ашиглаж оюутны бие даах хэсгийг өөрсдөөр нь тохижуулсан нь сайшаалтай байв.



- Тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, лаборатори, урлангийн хангалт, ашиглалтын байдал

Оюутны суралцах орчин, лаборатори, студийн тоног төхөөрөмж маш сайн. Практик, дадлагын хичээлд ашиглагддаг техник, тоног төхөөрөмжүүд нь мэргэжлийн шаардлага хангасан байна. Дууны студи, дүрс бичлэгийн студи, кино театрууд нь бүрэн тоноглогдсон учир оюутны дадлагад суурилсан хичээлүүд, мэргэжлийн ур чадварт сайнаар нөлөө үзүүлдэг. Ихэнх жижиг телевиз, сургуульд байдаггүй техник, тоног төхөөрөмж ашигладаг нь материаллаг бааз, орчинд ихээхэн анхаарч хөрөнгө, мөнгө

зарцуулсан байна. БСШУСЯ-ны санхүүжилтээр 25 сая төгрөгний хөрөнгө оруулалт хийсэн байна.



Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

2.2 Сургалтын хэрэглэгдэхүүн, хэрэгсэл

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Программ хангамж, симуляци, виртуал лабораторийн хэрэглээ, хүртээмж

Сургалтанд шаардлагатай техник хэрэгсэлийн хүрэлцээ сайн. Мэргэжлийн шаардлагатай программ хангамжийн хичээлийн 35 компьютертэй. Хичээлийн хуваарийн дагуу болон нэмэлт цагаар хангалттай сууж ажилладаг нь оюутнуудтай хийсэн уулзалтаар баталгаажсан.



Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцдаа материаллаг баазад анхаарч гэрэл зураг угаах, монтажийн, гэрэлтүүлгийн сургалтын лабораторийн хүчин чадал, хэмжээг нэмэгдүүлэн ажиллаж байна.




Тус хөтөлбөр нь компьютер графикийн 8, 16, 20 суудалтай тус бүр 3 лаборатори, дууны технологийн лаборатори 1, кино үзвэрийн танхим-1, “АВ” теле студи, “Дебют” оюутан театр зэрэг хөтөлбөрийн үзэл баримтлал, заах арга зүйд тохирсон хичээлийн материаллаг баазыг бүрдүүлэн ажиллаж байна. Тухайлбал, 2013 онд 16.995.010 төгрөг зарцуулсан бол 2014 онд 65.218.580 төгрөгний худалдан авалт хийсэн байна. Сургалтандаа Adobe

photoshop CS3, ADOBE Illustration CS3, Corel, In Design Cubase 5, Sound Forge Pro зэрэг мэргэжлийн программ хангамжуудыг ашигладаг. Түүнчлэн суралцах анги танхим, мэргэжлийн лабораторийн тоог нэмэгдүүлснээр дадлага хийх, багаар ажиллах, туршилт хийх боломжийг бүрдүүлсэнд оюутнууд сэтгэл ханамж өндөр байгаагаа илэрхийлж байсан.

- Хичээл практикийн материаллаг нөөц, хэвлэмэл үзүүлэн, тараах материал, хэрэглэгдэхүүний хүртээмж, хэрэглээ

Хичээлд шаардлагатай багшаас болон сургуулиас олгогддог тараах материал хангалттай өгдөг. /оюутнуудаас авсан санал асуулга/



- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмжийн хүртээмж

Багш суралцагчдын сургалтанд шаардлагатай гарын дор байх материал, багаж хэрэгсэлд зарцуулдаг төсөв маш байсан. Үүнийг суралцагчдын төлбөр дээр нэмэлт суутгал авч шийдсэн нь зөв шийдвэр байв.





Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

2.3 Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт мэдээллээр тогтмол, чанартай хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн судалгаа, хүртээмж, хэрэглээ
 - Мэргэжлийн онцлогоос хамаарч туршлагатай багш нарын гаргасан гарын авлага номыг сургалтандаа ашигладаг, гадаадын мэргэжлийн ном ашигладаг байна. Оюутнууд нь СУИС-ийн төв номын сан, Соёлын сургуулийн номын сан, Радио, телевиз, медиа урлагийн сургуулийн номын сангийн 60000 гаруй ном, уншлагын 8 танхимыг ашигладаг.



- Виртуал, дижитал видео, аудио болон бусад цахим эх үүсвэрүүдийн байдал
 - Мэргэжлийн багш нарын ур чадварын хичээлүүдийг “Дамжуулах үг” төслөөр видео болгон авч үлдэж байгаа нь маш хэрэгтэй төсөл явагдаж байна. 2016 оноос эхлэн дуу, дүрс бичлэгийн архивтай болж Монголын уран сайхны кино



100 ширхэг, орчуулгын кино 100 ширхэг, дэлхийн шилдэг кино 100 ширхэг (орчуулгаггүй) баримтат кино 25 ширхэг, бусад материал 130 гаруй, бакалаврын оюутны бүтээл 100 ширхэг тус тус хадгалж, оюутнуудад виртуал сургалт явуулахад ашиглах боломжтой байгаа нь сайшаалтай байна.

- Цахим орчны хүртээмж, хэрэглээ, Сургалт, судалгааны лицензтэй программын ашиглалтын байдал
 - Цахим хэрэглээ, дижитал дуу, дүрсийн эх үүсвэрүүдийн хүрэлцээ хангалттай хийгдэж байгаа нь нотлох баримтуудаар нотлогдсон. Тухайлбал, дэлхийн сүлжээний технологиор тэргүүлэгч Cisco –ийн өндөр хүчин чадал бүхий тоног төхөөрөмжүүдийг (Cisco pix firewall, Cisco catalyst- 3750) суурилуулсан.
 - Мэргэжлийн сургалтанд ашиглагддаг програм хангамжууд нь лицензтэй байна.



Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Номын сангийн уншлагын танхим нэмэх шаардлагатай.
- СУИС-ийн номын сан нь орчин, уншлагын танхим нь сайн боловч оюутнууд очдоггүй. Үүнийг холбож өгөх ажил хийгдэх шаардлагатай.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан.

ШАЛГУУР 3. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

3.1 Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдал:

- Уг хөтөлбөр бусад хөтөлбөрийн нэгэн адил СУИС-ийн удирдлагын мэдээлийн UNICULTURE системийг сургалтын үйл ажиллагаандаа хэрэглэдэг. Уг систем нь сургалтын алба, багшийн вэб, оюутны вэб, хүний нөөцийн вэб онлайн тестийн вэб зэрэг бүтэцтэйгээр ажилладаг. Оюутнууд дүнгээ харах, өөрийн үнэлгээний чанарт хяналт тавих, хичээлийн хуваарь, багш, оюутны дэлгэрэнгүй мэдээлэл авах, оюутны

санал асуулгын судалгаа авах, сургалтын төлбөрийн мэдээлэл авах, багшаа сонгох, багшийг үнэлэх зэрэг олон боломжтой сайн ажиллаж байна.

- Хөтөлбөрийн удирдлага нь хөтөлбөрийн дэд хороо, Ерөнхий хороо гэсэн бүтэц зохион байгуулалттай ажилладаг бөгөөд оролцогч талууд нь ажил олгогч 30 хувь, төгсөгч 10 хувь, оюутан 10 хувь багш 25 хувь, мэргэжлийн байгууллага 25 гэсэн бүтэцтэйгээр нэмэгдүүлэн судалгаа, уулзалт, агуулгын шинжилгээ хийж ажилладаг.
- Хөтөлбөрийг тасралтгүй сайжруулах чиглэлээр сүүлийн таван жилд 9 удаагийн хэлэлцүүлэг, санал, судалгааг хийж ажилласан.

Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд шаардлагатай дүрэм, журмуудын хэрэгжилт:

- Дээд боловсролын тухай хууль, БСШУСЯ-наас гаргасан холбогдох журам, тушаалыг мөрддөг бөгөөд тэдгээр журмын дагуу тухайн сургууль холбогдох журмыг гаргаж мөрдөн ажилладаг байна.
- 2014 оны 05 сарын 22-ний 104 тоот тушаалаар батлагдсан хөтөлбөрийн хорооны журам
- СУИС-ийн захирлын 2014 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 115 тоот тушаалаар 9 хүний бүрэлдүүнтэй хөтөлбөрийн хороо ажиллаж байна.
- Хөтөлбөрийн эцэслэн батлуулах ажлын хэсгийн төлөвлөгөө, гишүүдийг батлан ажилласан байна. / 2015 оны 11 дүгээр сарын 27-ны 304 дугаар тоот тушаал /
- 2016 оны 01/11-ны А/01 тоот тушаалаар бакалаврын хөтөлбөрийг редакторлах комисс байгуулан ажилласан.
- СУИС-ийн бакалаврын сургалтын журам/ 2015 оны А/149 тоот тушаал/
- СУИС-ийн хөтөлбөрийн хорооны журам/2014 оны А*104 тоот тушаал/

Урт болон богино хугацааны төлөвлөлт, гүйцэтгэлийн тайлан, ахиц өөрчлөлтийн дүн шинжилгээ механизм

СУИС-ийг хөгжүүлэх мастер төлөвлөгөөний дагуу 2012-2021 он хүртэл хөгжүүлэх 8 зорилт, 32 стратегийн шалгуур үзүүлэлтүүдийг гаргаж мөрдлөг болгон ажилладаг бөгөөд энэ төлөвлөлтийн дагуу үйл ажиллагааны төлөвлөлтийг хийж жил бүр ахиц дэвшлийг гарган ажилладаг. Ахиц дэвшлийн тайлан нь нийт 9 бүлэг бүхий шалгуур үзүүлэлтээр дүгнэж тайлагнадаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах зөвлөмж :

- Хөтөлбөрийн хороонд ажил олгогч, оюутны төлөөллийг оролцуулж албажуулах талаар анхаарч ажиллах;
- Удирдлагын мэдээллийн систем нь санхүүгийн программд холбогдоогүй байгаа нь бэрхшээлтэй байгааг анхаарах;

- Урт болон богино хугацааны төлөвлөлтийн тайлангийн шалгуур үзүүлэлтэд чанарын үзүүлэлтүүдийг оруулах талаар анхаарч ажиллах

3.2 Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- **Хөдөлмөрийн зах зээлийн тандан судалгааны давтамж**

Хөтөлбөрийн оролцогч талууд, ажил олгогч, мэргэжлийн байгууллагаас хөтөлбөрийн эрэлт хэрэгцээ, мэргэжилтний ур чадварын талаар судалгаа, хэлэлцүүлгийг хийдэг ба Улаанбаатар хотод байршилтай нийт 9 телевизээс судалгаа авч хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн хэмжээг тодорхойлсон байна. Монгол орны мэдээлэл харилцааны салбарын хөгжил, хувийн хэвшлийн хөгжлийн үр дүнд шударга өрсөлдөөнийг дэмжих нэрийдлээр 2005 оноос телевизийн тусгай зөвшөөрлийг уралдаант байдлаар олширч эхэлснээр арилжааны телевизүүд олноор бий болж, зураглаач мэргэжлийн эрэлт хэрэгцээ эрс өссөн юм. Өнөөдрийн байдлаар Монгол улсад тусгай зөвшөөрөл бүхий 88 телевиз, 75 кабелийн суваг үйл ажиллагаа явуулж байна. Тиймээс уг хөтөлбөр нь нийгмийн эрэлт хэрэгцээнд суурилсан тул элсэгчдийн тоо тогтвортой нэмэгдэж байгаа.

- **Хөтөлбөрийн сурталчилгаа, идэвхжүүлэлтийн арга хэлбэр, хүртээмж, үр нөлөө**

Хөтөлбөрийн талаар маркетингийн идэвхижүүлэлтийн хөтөлбөр байхгүй хэдий ч хөтөлбөр, сургуулийн талаарх мэдээллийг олон нийтийн мэдээллийн суваг ашиглаж түгээдэг байна. Тухайлбал, хамтарч ажилладаг телевизэд нэвтрүүлэг бэлтгэх, үзэсгэлэн зохион байгуулах, уралдаан тэмцээн зохион байгуулж олон нийтэд хүргэдэг талаарх тайлан, фото зургийг бид баримт нотолгоогоор танилцсан. Мөн түүнчлэн тус хөтөлбөрийг сурталчлах, олон нийтэд таниулах зорилгоор үзэсгэлэн, радио телевизийн шторк, мэргэжил сурталчлах өдөрлөг, улсын болон ТББ-аас зохион байгуулдаг уралдаан тэмцээнүүдэд оролцох, мэргэжлийн байгууллагуудад дадлага хийх зэрэг үйл ажиллагааг тогтмол явуулдаг. Үүнээс гадна мэдээллийн олон төрлийн хэрэгслийг сүүлийн жилүүдэд идэвхитэй ашиглан, хэрэгжүүлж иржээ. Тухайлбал, хамтарч ажилладаг телевиз, радио, сонин сэтгүүл, сургуулийн вэб сайт, фэйсбүүкийг ашигласнаар байгууллагын зөв имидж бүрдүүлэх, олон нийтэд нээлттэй, ил тод байдлыг хангахад их ач холбогдолтой юм.

Онцлог зүйл/Туршлага:

Төсөлд суурилсан сургалтаар багш, оюутнууд курсын болон дипломын ажлаараа уран бүтээл хийж, дотоодын болон олон улсын уралдаан, үзэсгэлэнд бие даан оролцох зэргээр олон нийтэд хүргэж байна. Цахим хуудсанд орсон мэдээллийг фэйсбүүкээр давхар дамжуулдаг нь хэрэглэгчдийн хандалтыг тодорхойлж, дүгнэлт хийх боломжийг олгодог давуу талыг ашиглаж, онлайнаар байршуулсан байна.

Анхаарах асуудал:

- Байнгын мэдээллийн админийг хавсарч биш орон тооны мэргэжлийн хүнээр томилон ажиллуулах хэрэгтэй.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3.3 Төгсөлтийн дараах бодлого

Хөтөлбөр нь төгсөгчидтэйгээ байнгын эргэх холбоотой, тэдний мэргэжлийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулж, төгсөгчид нь суралцаж буй суралцагчдад мэргэжлийн чиглэлээр ажиллахад нь зөвлөн тусладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- *Төгсөгчдийн карьерын өсөлтийн судалгаа*
- Мэргэжлийн болон хувь хүний чадамжийн үнэлгээ нь 4.2-4.3 буюу сайн үнэлгээтэй байдаг.
- 2012-2017 оны 5 жилийн судалгаагаар нийт төгсөгчдийн 80-85 хувь нь ажлын байртай болсон. Харин төгсөгчдийн 10 хувь нь студийн захирал, программын албаны дарга, бодлого төлөвлөлтийн менежер, мэдээллийн албаны дарга, хувийн студийн менежер, захирал болж мэргэжлээрээ ахиж дэвшсэн байдалтай байна.
- *Үргэлжлүүлэн суралцагчдын хувь хэмжээ*
- Үргэлжлүүлэн суралцагчийн хувь 0,06 хувь байна. Төгсөгчдөөс 2 оюутан магистрын зэрэг хамгаалсан байна. Төгсөгчдийн хувьд ахисан түвшиний сургалтад хамрагдах нь бусад мэргэжлийнхээс бага байдаг нь мэргэжлийн онцлог, ажлын хэт их ачааллаас хамааран сургалтанд сууж мэргэжлээ дээшлүүлэх цаг хомс байдаг талаар сургуулийн багш ажилтан төдийгүй төгсөгч, ажил олгогчид онцолсон.
- Төгссөн хугацаанаас хамаарч, төгсөгчдийн 20 гаруй хувь нь давтан сургалтанд хамрагдах, давхар мэргэжлээр мэргэших сонирхлын дагуу хэд хэдэн удаагийн сургалтыг зохион байгуулсан нь үр өгөөжөө өгсөн тул цаашид улам боловсронгуй болгон, үргэлжлүүлэх үйл ажиллагааг эрчимтэй явуулж байна.
- Төгсөгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхийн тулд ахисан түвшний буюу магистрын сургалтын хөтөлбөрийг бие даасан бүтэцтэйгээр байгуулж, төгсөгчдийг үргэлжлүүлэн сурах боломжоор хангасан.
- *Төгсөгчдийг давтан сургалтад хамруулах бодлого, төлөвлөгөө, хамрагдсан байдал*

Уг хөтөлбөр нь төгсөгчдөө чадавхжуулах зорилгоор мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг мэргэжлийн байгууллагад ажиллаж байгаа уран бүтээлчдэд зориулан, NTV, MNB зэрэг телевизүүдтэй гэрээ байгуулан, сургалт явуулж байна.

- **Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны тогтмолжсон байдал**

2016 онд төгсөгчдийн холбоог 18 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг жилд 2 удаа тогтмол хийж, төгсөгчдөө урьж ярилцлага хийх, оюутнуудыг ажлын байранд хэрхэн бэлдэх тухай зөвөлгөө авах, төгсөгчдөөр зуучлуулж, дадлага хийх, ажлын байртай болох гэх мэт ажлуудыг гүйцэтгэж байна. Мөн төгсөгчдийн холбооноос санаачлан шилдэг оюутныг урамшуулах сан байгуулж ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш, оюутан, төгсөгчдийн харилцаа холбоо, хамтын ажиллагаа нягт, төгсөгчид нь сургуульдаа сэтгэл хангалуун, багш нараараа бахархаж, үргэлж дэмжиж явдаг нь харагдлаа.
- Төгсөгчдийн мэдлэг, чадварын үнэлгээг өөрийн сургуулийн бусад хөтөлбөртэй харьцуулсан судалгаанаас харахад онолоос илүү практик талын мэргэжлийн ур чадвар эзэмшсэн байдал нь илт давуу байгаа нь харагдсан.
- Мастер класс гэх гадаадын уран бүтээлчдийг урин авчирч, богино хэмжээний туршлага судлах сургалт зохион байгуулдаг нь дэвшилттэй юм.

3.4 Олон улсын харилцаа, хамтын ажиллагаа

Олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- **Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн тайлан, дүгнэлт**

Уг хөтөлбөрийн хүрээнд мэргэжил нэгт гадаадын 5 орны их дээд сургуулиудтай хамтын ажиллагааг тогтвортой хэрэгжүүлж байгаа бөгөөд 2017 оноос ОХУ, АНУ, Турк, Япон, БНСУ-ын кино, телевизийн сургуулиудтай хамтран ажиллах санал хүсэлтээ хүргүүлээд байгаа. Гадаад хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж буй 6 төсөл хөтөлбөрт 20 гаруй багш, давхардсан тоогоор 150 гаруй оюутнууд хамрагдсан байна.

- **Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоо**

Багш солилцооны хөтөлбөрийн хүрээнд БНХАУ-ын Шанхай хотод 2 жилийн хугацаатай дадлагад 6 багш, ХБНГУ-ын Дортмундын технологийн их сургуульд 4 багш, 10 гаруй оюутан, Австралийн их сургуулийн тэтгэлгээр 1 багш мэргэжил дээшлүүлж, олон улсын гэрэл зургийн уралдаанд оролцон, тэргүүн байр эзэлсэн байна. Оюутан

солилцооны хүрээнд БХНАУ-ын ӨМӨЗО-ны Багшийн сургуультай байгуулсан гэрээгээр 2014 оноос хөтөлгөч, нэвтрүүлэгчийн 14 оюутанг хамруулсан сургалт, дадлага зохион байгуулсан.

- Олон улсын хурал семинар, судалгаа болон бусад арга хэмжээнд оролцсон тоо, үр дүн, ач холбогдол

Хөтөлбөрийн хүрээнд 6 орны 10 гаруй их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажилладаг. Америк, Польш зэрэг орнуудаас нэртэй найруулагч, зураглаач нараар нийт 14 мастер класс сургалт зохион байгуулж, нийт оюутнуудаа хамруулж, хэлэлцүүлэг зохион байгуулж, баримтат нэвтрүүлгийг телевизүүдээр цацаж, Азийн урлагийн сургуулиудын 4 наадамд оролцсон 8 орны 8 өөр жүжиг болон мастер классыг бичиж, сургалтын хэрэглэгдэхүүн болгон ашиглаж байгаа зэрэг нь олон улсын түвшинд хүрэхэд ихээхэн анхаарч ажиллаж байгаа нь харагдаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

• Азийн кино урлагийн чиглэлийн их дээд сургуулиудын оюутны 2-р наадамд 2 бүтээл шалгарсан. Мөн Японд зохион байгуулагдсан Олон улсын гэрэл зургийн наадамд нэг багш тэргүүн байр эзэлсэн. 2016 оны Олон улсын кино наадамд 2 бүтээл шалгарсан. Бээжин, Санкт-Петербургт хотуудад болох оюутны наадамд оролцох урилга хүлээн авсан байгаа зэрэг нь Олон улсад мэргэжлийн ур чадвараараа үнэлэгдэх болсныг гэрчилж байна.

Зөвлөмж:

- Суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрийн тоо, чанарыг нэмэгдүүлэх

3.5 Дотоод хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нь мэргэжлийн холбоод, үйлдвэр, үйлчилгээний байгууллагууд, ажил олгогч эздийн холбоо, төрийн болон ТББ-уудтай хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хамтран ажиллах гэрээ, хэлцэл, ажлын үр дүн

Тус хөтөлбөр нь 10 гаруй мэргэжлийн урлагийн байгууллага, 3 төрийн бус байгууллага, 5 их дээд сургуультай хамтран ажилладаг. Оюутнуудын үйлдвэрлэлийн дадлагыг МҮОНТ-тэй 3 сарын хугацаатай хийж, хөдөө орон нутгаас сурвалжлага бэлтгэх, шууд нэвтрүүлэг явуулахаас гадна мэргэжлийн уран бүтээлчдийг урьж, сертификаттай сургалт зохион байгуулдаг. Түүнчлэн БСШУСЯ-ны дэмжлэгтэйгээр Хүй долоон худагт “Соёлын наадам” нүүдэлчдийн фестивалийг жил бүр зохион

байгуулдаг. Үйлдвэрлэлийн танилцах дадлагыг Кино үйлдвэрийн дэргэдэх архивын газарт хийж, Монголын кино урлагийн түүх хичээлийн агуулга, сургалтын арга хэлбэрт өөрчлөлт оруулсан ахиц дэвшил авчирсан.

- Хэрэгжүүлж буй ажлуудын тайлан, дүгнэлт
- Хамтын ажиллагааны арга, туршлага
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо үр дүн /багш, суралцагчдын зүгээс/

[Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан](#)

Онцлог зүйл/Туршлага:

- 60 гаруй бүтээлийг 5-6 TV-ээр эфирт цацсан. АТЕК-ийн хүндэтгэлийн тоглолт, Соёлын наадам, Уртын дууны наадам, Монголын дуурийн ханхүү гэх мэт.
- Мэргэжлийн байгууллагуудад сургалт дадлага хийх гэрээ байгуулан, хичээлийн бус цагаар үйлдвэрлэлийн дадлага хийж, цаашид үргэлжлүүлэн ажлын байраар хангагддаг.
- 2010 оноос хойш “Соёлын наадам”, “Кино сонирхогч хүүхдүүд” зуны сургалтыг тогтмол зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

- Эрдэм шинжилгээ, төсөлт ажилд оюутнуудаа идэвхитэй оролцуулж, сургууль болон мэргэжлийн онцлогоо сурталчлан таниулах үйл ажиллагааг идэвхижүүлэх

Зөвлөмж:

- Соёл, урлагийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, хамтарсан уран бүтээл туурвих

3.6 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- [Төсөв, санхүүгийн бие даасан байдлын хөгжил](#)

Нийт санхүүжилтийн 89,91 хувь нь үндсэн үйл ажиллагааны зардал буюу хичээл сургалт, эрдэм шинжилгээ, оюутны үйлчилгээний зардалд зарцуулагддаг. “Зураг авалт” хөтөлбөрийн хүрээнд сургалтын багц цагийн үнэлгээгээр тооцон төвлөрүүлдэг. Сургалтын хөтөлбөрийн төлбөрийг жил бүр СУИС-ийн Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталдаг. 2015-2016 оны нэг багцийн үнэлгээ 50 917-61 565 төгрөг байна. Уг хөтөлбөрийн нэг онцлог нь хичээлүүд нь ганцаарчилсан болон бага, дунд бүлгээр зохион байгуулагддаг тул нэг багшид ноогдох оюутны тоо цөөн, үүнийг дагаад цалингийн зардал нь СУИС-ийн хэмжээнд нийт орлогын 60-70 хувийг эзлэдэг.

- **Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо**

Сүүлийн 3 жилд элсэгч оюутны тоо буурсан боловч нэг оюутанд ноогдох шууд зардал тодорхой хэмжээгээр өссөн байна.

- **Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв**

2012-2017 он хүртэлх 5 жилийн төсөвлөсөн графикаас харахад тус мэргэжлийн хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудад зориулсан арга хэмжээний төсөв жил бүр нэмэгдсэн байна. Сургалтын орчныг сайжруулах талаар сүүлийн 5 жилд хичээлийн байрны коридор, анги танхимууд, багш нарын өрөө, оюутны зөвлөлийн өрөө, багшийн амрах өрөө, коридорын гэрэлтүүлэг, хана, хаалга зэргийг орчин үеийн нөхцөл шаардлагад нийцүүлэн, оюутнуудын бүтээлч сэтгэлгээ, ур дүйтэй хослуулан, засварлаж, нийтийн бие засах газруудыг шинэчлэн тохижуулсан байна. Дууны лаборатори, “Дебют” оюутан театр, “АВ” студи, компьютерийн лабораторийг засварлан, шинэ техник технологиор тоногдсон байна. Дуу дүрсийн архивыг сургалтын үйл ажиллагаанд хэрэглэх зорилгоор байгуулсан байна.

- **Төр хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалт**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад багш нар шинжлэх ухааны болон суурь судалгааны төсөл хэрэгжүүлэх, захиалгат болон гэрээт ажлыг гүйцэтгэх, мэргэжлийн сургалт зохион байгуулах, уран бүтээл туурвих зэрэг үйл ажиллагааныхаа орлого хандивыг сургуульд болон тэнхимд төвлөрүүлдэг. Сүүлийн жилүүдэд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш, оюутнуудын гадаад, дотоодын төсөл, уралдаан тэмцээн, захиалгат, гэрээт ажил, гүйцэтгэх хувь, цар хүрээ өссөнтэй холбоотойгоор тодорхой хэмжээний орлогын эх үүсвэрийг бий болгож байна.

- **Төсвийн уламжлалт бус эх үүсвэр, бүрдүүлэлт, хуваарилалт, санхүүжилт**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар судалгаа шинжилгээний ажлын санхүүжилт ба бусад үйл ажиллагааны үр дүнгээс бэлэн мөнгөөр болон ном, сурах бичиг, бусад сургалтын материалын хандивыг тэнхим, сургуульдаа өгдөг байна.

- Оюутанд үзүүлэх үйлчилгээний зардлыг сургуулийн төсөвт тусгаж, тэнхим болон оюутны холбоогоор дамжуулан санхүүжилт авдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Урлагийн мэргэжлийн сургалт нь ганцаарчилсан болон бага, дунд бүлгээр ихэнхи хичээлүүд нь зохион байгуулагддаг онцлогтой. Энэ нь нэг багшид ногдох оюутны тоо багасах, оюутанд очих шууд зардал нэмэгдэх, мэргэжлийн ур чадварт нь сайнаар нөлөөлнө.
- БСШУС яамны хөрөнгө оруулалтаар Дебют театр болон студи, 00 өрөөг тохижуулсан.

Анхаарах асуудал:

- Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх замаар багш нарын сургалтаас гадуурх орлогыг нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Хувийн хэвшлийн дэмжлэг авах төсөл төлөвлөгөө боловсруулах
- “Гэрэл зургийн лаборатори” байгуулах төслөө батлуулах

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

4.1 Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- *Суралцагч элсүүлэх эрх зүйн зохицуулалтад хөтөлбөрийн онцлогт нийцсэн шалгуурыг тусгасан байдал*

Зураг авалт” хөтөлбөрөөр БСШУС сайдын тушаалаар баталсан “Оюутан элсүүлэх үлгэрчилсэн журам”, СУИС-д “оюутан элсүүлэх журам”-ыг мөрдлөг болгодог бөгөөд 2012 оноос элсэгчдээс авдаг мэргэжлийн ур чадварыг шалгах шинэлэг аргачлалыг боловсруулан, хэрэгжүүлж байна.

- *Элсэгчдийн ЕШ-ийн дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа*

Төрийн захиргааны байгууллагын захиалга, зах зээлийн эрэлт хэрэгцээ, сургуулийн материаллаг бааз, багшлах бүрэлдэхүүний хангамж зэргийг харгалзан БСШУСЯ-аас баталсан элсэгчдийн хяналтын тоонд багтаан оюутан элсүүлдэг. 2012-2013 онд 27 оюутан, 2013-2014 онд 29 оюутан, 2014-2015 онд 18 оюутан, 2015-2016 онд 23 оюутан, 2016-2017 онд 22 оюутан элсүүлсэн байна. Элсэгчдийн ЭЕШ-ийн оноо сүүлийн 3 жилийн байдлаар 500 хүртэлх оноотой 12 оюутан, 600 хүртэлх оноотой 33 оюутан, 600 –аас дээш оноотой 8 оюутан элсэн орсон нь тус мэргэжлээр элсэгчдийн элсэлтийн шалгалтын оноо харьцангуй өндөр үзүүлэлттэй байгаа нь харагдаж байна.

- *Шинээр элссэн суралцагчдыг чиглүүлэх сургалтад хамруулж, мэдээлэл, гарын авлагаар хангасан байдал*

Шинээр элсэгчдэд оюутны гарын авлага, оюутны дэвтэр, сургуулийн танилцуулга МАР-ийг сургуулийн сургалтын алба, зөвлөх багшийн оролцоотойгоор оюутан бүрт олгож, тайлбарлаж өгдөг байна. Шинээр элссэн оюутнуудад зориулсан өдрийг оюутны зөвлөлтэйгээ хамтран зохион байгуулдаг. Элсэгчдэд СУИС-ийн бүрэлдэхүүн сургууль, сургалтын алба, санхүүгийн алба, номын сан, оюутны дотуур байр зэргийн байршил, дотоод зохион байгуулалтыг харуулсан зураглал бүхий хэвлэмэл материал тараасан нь их үр дүнтэй болсон байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2012 оноос мэргэжлийн ур чадварыг шалгах зураглаач багш Л.Шаравдоржийн боловсруулсан шинэлэг аргачлалыг оюутан элсүүлэх журамдаа тусган, хэрэгжүүлж байгаа. Үүнд: харааны баримжааг тогтоох арга, өнгө ялгах арга, гэрэл сүүдрийн баримжааг тогтоох, урьд нь бэлтгэсэн өөрийн авсан гэрэл зургийг тайлбарлах, сэтгэхүйн ерөнхий чадварыг тестээр шалгах, эссэ бичих зэрэг аргууд нь элсэхийг хүсэгчийн бүтээлч чадвар, сэтгэн бодох чадварыг мэргэжлийн онцлогт тохируулан шалгаж авдаг болохыг илтгэж байна.

Зөвлөмж:

- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ их байгаа тул элсэгчдийн хяналтын тоог нэмэх

4.2 Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчдад суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогмол, чанартай үзүүлдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- *Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, график, үр дүн*

Оюутанд зөвлөх үйл ажиллагаа нь сургалт, хүмүүжлийн үйл ажиллагааг бүхэлд нь хамарсан өргөн хүрээтэй ажил юм. 2011 онд боловсруулсан СУИС-ийн “Оюутны хөгжил” хөтөлбөрийн хүрээнд жил бүр гүйцэтгэдэг. Энэ нь байнга тасралтгүй, системтэй явагддаг бөгөөд оюутныг чиглүүлэх, зөвлөх үйлчилгээ, оюутны хөдөлмөр эрхлэлт, оюутны дотуур байр, “Харзтай” эко зуслан дадлагын бааз, оюутны санаачлагатай төсөл хөтөлбөр, тэтгэлэг хөтөлбөрт хамруулж, санхүүгийн дамжлэг

үзүүлэх үйлчилгээ, оюутан солилцооны хөтөлбөрт хамруулах, сайн дурын ажил, нийгмийн үйлчилгээ, соёл, эрүүл мэнд, спорт наадам, оюутны байгууллага, зөвлөл, клубууд ажиллуулах, гадаад оюутанг дэмжих үйлчилгээ зэрэг ажлуудыг үе шаттайгаар төлөвлөж хэрэгжүүлдэг.

- *Зөвлөх багш, сургалтын туслах ажилтан, сургалтын менежер, арга зүйч, байрны багш, эмч, сэтгэл зүйч нарын үйлчилгээний чанарын үнэлгээ, сайжруулалт*

Оюутанд зөвлөх багш, сургалтын туслах ажилтан, сургалтын менежер нар үйлчилгээ үзүүлдэг бөгөөд үйлчилгээ, хүртээмжээ сайжруулах үүднээс суралцагчдын сэтгэл ханамжийн судалгааг сүүлийн 3 жил дааралан авсан байна. Судалгаанаас харахад нийт суралцагчдын 70 хувь нь сургалтын орчин, сургалтын үйл ажиллагааны талаарх мэдээллийг зөвлөх багш нараас авдаг байдал, хичээл зааж байгаа багш нарынхаа заах арга зүйд хангалттай гэсэн үнэлгээ өгсөн нь сайшаалтай юм.

- *Бие хүний төлөвшил, харилцаа, ёс зүйн /зан үйл, зөрчил шийдвэрлэх, эрүүл аж төрөх г.м/ чиглэлүүдээр сургалт явуулж, ур чадвар олгодог байдал*

Соёл урлагийн ажилтан, уран бүтээлч нь нийгмийг урагшлуулдаг түүчээ нь байх ёстой гэдэг зарчмаар “Оюутны хөгжил” хөтөлбөрийн хүрээнд “Оюутны хөгжил-анхны алхам 1, 2”, СУИС-ийн тэргүүний оюутны чуулга уулзалт, спорт наадам, сургууль сурталчлах нээлттэй хаалганы өдөр, “Авъяастны эрэлд” урлагийн наадам, эрүүл мэнд, олон нийтийн цэвэрлэгээ, хандивын аян, эх хэлний баяр, “Бид сайн сайханд дагуулна” гудамжны баяр, өргөн зугаалга, яруу найраг, спорт сонирхогчдын клуб зэрэг үйл ажиллагааг тогтмол явуулж байна. 2016-2017 онд Америк, Польш, Япон, Франц, ОХУ-ын найруулагч, гэрэлтүүлэгч, эрдэмтэн багш нарын 13, дотоодын 16 мастер класс хичээлийг зохион байгуулсан байна.

- *Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлыг үнэлдэг байдал*

2016 оны 4 сард БСШУСЯ-аас Банкны зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй төслийн хүрээнд “оюутны санаачлагыг дэмжих” төслийн өрсөлдөөнт тэтгэлэгт тус сургуулийн “Медиа эвлүүлгийн лаборторийн орчныг сайжруулах” төсөл шалгарч, амжилттай хэрэгжсэн. СУИС-ийн захирлын 2017 оны А/115 тоот тушаалаар “Бүтээлч оюутан” төсөл зарлагдснаас “Элсэлтийн сурталчилгааны анимейшн шторк” төсөл шалгарч, санхүүжилтээ авдаг.

- *Суралцагч, төгсөгчдөд хөдөлмөрийн биржийн үйлчилгээ үзүүлдэг байдал*

“Төгсөх оюутны өдөрлөг”-ийг жил бүр зохион байгуулж, ажил эрхлэгчдийг оролцуулан хамтран ажилладаг байна. Сургуулийнхаа нөөц бололцоондоо тулгуурлан, сургууль дээрээ ажлын байр гарган, ажил мэргэжлийн дадлага туршлага олгох ажиллагааг хэрэгжүүлж байна.

- *Суралцагчийн судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг дэмжин тусласан байдал*

Зураг авалт хөтөлбөрийн тэнхимийн зүгээс техник технологийн сүүлийн үеийн ололт, шинэ мэдээллийг уран бүтээл дээр ашиглах, практик дадлагад хэрэгжүүлэх, шилдэг бүтээл, илтгэл шалгаруулах зорилгоор жил бүрийн 4 сард Оюутны эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулдаг.

Шанхайн театр киноны академитай хамтарсан зуны дадлагын зураг авалтад 10 гаруй оюутан хамрагдсан бөгөөд үүнд зарцуулагддаг төсөвийг сургуулиас гаргадаг байна. “Gamma” агентлагийн гэрэл зургийн лабораторид оюутнуудынхаа дадлагын ажлыг хийлгэдэг бөгөөд хийсэн бүтээлийг нь тогтмол гадаад, дотоодын уралдаан тэмцээнд дэмжин оролцуулдаг байна. Кино найруулагын, зураглаачийн ангийн төгсөгчид хамтран дипломын ажлаараа хийсэн “Хайрын клуб” уран сайхны киног япон багш орчуулж, Киотогийн оюутны наадамд оролцуулж, сургуулийхаа Дебют театртаа төлбөртэйгээр хүүхдүүдэд үзүүлж, кино бүтээсэн зардалдаа хандивласан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутны ажлын байрыг өөрийн сургууль дээрээ бий болгож, цалинжуулдаг.
- Зуны дадлагын зардлын 70 хувийг оюутны бүтээлийн зураг авалтанд зарцуулдаг нь бүтээлээрээ Олон улс болон дотоодын уралдаан тэмцээнд оролцоход чухал түлхэц өгдөг.

4.3 Оюутны байгууллагад үзүүлэх дэмжлэг

Оюутны байгууллагаас санаачилсан нийгэмд үзүүлэх үйлчилгээг дэмжин хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- *Оюутны сайн дурын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, дэмжсэн байдал*

Оюутны зөвлөлөөс зохион байгуулдаг ажлын төлөвлөгөөг жил бүр сургуулийн захирал баталж, холбогдох төсөвийг баталдаг байна.

“Оюутан хөгжлийн төв”-ийг засварлан, үйл ажиллагааг нь хэвийн явуулахад зориулан тусгайлан ороог нь тохижуулсан байна.

- *Оюутны байгууллагын үйл ажиллагааг явуулах төсөв, клубын үйл ажиллагааг дэмжих санхүүжилттэй байх, зориулалтын дагуу зарцуулдаг байдал*
- РТМУС-ийн оюутны зөвлөл нь тодорхой хэмжээний санхүүжилтийг авдаг, хийсэн ажлын тайланг РТМУС-ийн захиргааны зөвлөлд тайлагнадаг байна.
- Зураг авалт хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудын арга хэмжээнд зарцуулсан төсөв сүүлийн 5 жилд өссөн үзүүлэлтийг хүснэгтээр гаргасан байна.

- *Оюутны байгууллагын зүгээс санхүүгийн зарцуулалтаа ил тод тайлагнадаг байдал*
- Оюутны зөвлөл нь сардаа нэг удаа хуралдаж, үйл ажиллагааныхаа тайланг нэгдсэн холбоондоо тайлагнадаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- РТМУС нь шилэн дансны системд орсон.

Зөвлөмж:

- 1996-2014 оны хооронд 18 дугаар хэвлэгдсэн “Оюутан” сэтгүүлийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх

4.4 Суралцагчийн урамшууллын тогтолцоо

Суралцагчдын амжилтыг хөхүүлэн дэмжих урамшууллын системтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- *Урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын тоо*
- Зураг авалт хөтөлбөрөөр 2012-2015 оны хооронд хөнгөлттэй зээлд хамрагдсан 4 оюутанд 650 000 төгрөг, сургалтын төрийн сангийн хөнгөлттэй зээлд сүүлийн 3 жилд 38 оюутан, буцалтгүй тусламжид 101 оюутан, төрийн албан хаагчийн хүүхэд 30 оюутан хамрагдсан байна.
- 2013 оноос нийт оюутнуудад сургалтын тэтгэлэг олгож эхэлсэн бөгөөд 2013 онд 125, 2014 онд 124 оюутан хамрагдаж байсан. 2015 оноос уг тэтгэлэгийг олгохдоо сургалтын голч оноогоор тооцдог болсон тул жил бүр 10 гаруй оюутан хамрагдаж байна.
- Оюутныг урамшуулсан “Авъяастны эрэлд”, “Эх хэлний баяр”, “Анхны бүтээл” зэрэг 5 хөтөлбөрт 100 гаруй оюутны сургалтын төлбөрийг 50-100 хувь даах, уралдаан тэмцээнд орлцох замын зардлыг бүрэн хариуцах, захирлын нэрэмжит тэтгэлэг олгох, кино фестивалийг төлбөргүйгээр үзүүлэх, урлаг, спортын наадам, оюутны зөвлөлийн дарга, гишүүдэд урамшуулал цалин олгох ажлуудыг амжилттай гүйцэтгэжээ. Нийт зардлын 20 гаруй хувь нь тус хөтөлбөрөөр суралцагсдад зарцуулагдсан бөгөөд оюутны замын зардлын хөнгөлөлтөд сүүлийн 5 жилд 7-8 оюутан хамрагддаг. Энэ нь нийт оюутны 17 хувь болно.
- *Суралцагчдын үзүүлсэн амжилтууд*
- РТМУС нь оюутан залуусаа мэдлэг чадвар, бүтээлч сэтгэлгээгээ хөгжүүлэх боломжийг бүхий л талаар хангахыг зорьж ажилладаг бөгөөд өөрийн сургуульдаа уралдаан тэмцээн зохиохоос гадна гадаадын олон уралдаан тэмцээнд оюутнуудаа дэмжин оролцуулдаг байна. Тухайлбал, 2013 онд “Алтан хальс” Андерграунд кино уралдаанд “Үхэл бол төгс илбэ” бүтээл, зураглаачдын “Алмаз” улсын уралдаанд

“Сайн уу” бүтээлээрээ оюутны шилдэг бүтээл, “48 цаг” улсын уралдаанд “Надад гэрэл хэрэгтэй” бүтээлээрээ үзэгчдийн таашаал номинацийн шагналуудыг хүртсэн байна.

- 2008 оноос эхлэн “Анхны бүтээл” оюутны наадмыг улсын хэмжээнд, 2013 оноос олон улсын хэмжээнд зохион байгуулсан бөгөөд жил бүр тус сургуулийн оюутнууд манлайлан оролцож, тодорхой амжилтуудыг үзүүлсэн байна.
- *Сургуулиас үзүүлж буй урамшуулал, дэмжлэг*

РТМУС-нь оюутнуудад сурах идэвхи чармайлт, сурлагын чанарыг дээшлүүлэхийн тулд тодорхой шалгуур үзүүлэлтийг хангасан оюутнуудад шагнал, урамшуулал олгодог. Тухайлбал, шалгарсан бүтээлүүдэд хичээлийн явцын 70 оноог 50 гаруй оюутанд, сургалтын амжилт, нийгмийн идэвхи оролцоогоор нь “20 жилийн ойн нэрэжит” тэтгэлэгийг 2 оюутанд, “Хотын гудамж миний гэр” арга хэмжээнд оролцсон бүх оюутнуудад 1 кредитийн урамшуулал, гадаад дотоодын уралдаан тэмцээнд оролцох оюутнуудад санхүүгийн болоод техник тоног тохөөрөмжөөр тусламж дэмжлэг үзүүлдэг байна. Оюутнуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор “Оюутан туслах ажлын байр”-ыг гаргаж, сүүлийн 2 жилд 12 оюутныг хичээлийн бус цагаар ажиллуулан, 120 000 төгрөгөөр цалинжуулжээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутнуудын мэргэжлийн уралдаан тэмцээнд оролцох зардлыг даах, түрүүлсэн бүтээлүүдийг сургуульдаа үнэлэн худалдаж авдаг.
- Оюутнуудын мэргэжлийн хичээл дээр хийсэн богино хэмжээний анимейшн болон бүтээлийн төслийн ажлуудыг хичээлийн кредит, мөнгөн дүнгээр тооцож, урамшуулдаг.

Зөвлөмж:

- “Оюутан туслах” ажлын байрыг өргөжүүлэх

4.5 Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- *Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэсэн байдал*

2013-2017 он хүртэл хичээлийн жил нэг бүрээр шилжилт хөдөлгөөний судалгааг гаргасан байна. Шилжилт хөдөлгөөнийг зохицуулах үйл ажиллагаанд СУИС-ийн

сургалтын үйл ажиллагаанд холбогдох журмын 5.3 дугаар зүйл заалтын дагуу “Оюутны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах журам”-ыг мөрдлөг болгон ажилладаг. Суралцагчпын шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ / кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нийцүүлэн шийдэж байна.

- *Шилжилт хөдөлгөөний судалгаа, дүгнэлт*

Судалгаагаар хичээлийн нэг жилд 1-3 оюутан, нийт 10 оюутан шилжиж ирсэн байна. Шилжсэн 2 оюутан нь гадаадад суралцахаар явсан бөгөөд тодорхой шалтгаанаар сургууль завсардсан, сургуулиас гарсан 2-3 оюутныг сургалтын алба, зөвлөх багш нар хамтарч, эцэг эх, асран хамгаалагч нартай нь холбогдон тодруулах ажил явуулдаг.

- *Шилжилт хөдөлгөөнийг зохицуулж буй дүрэм, журам, гэрээний хэрэгжилт, суралцагчийн эрх ашгийг дээдэлсэн байдал*

Оюутны шилжилт хөдөлгөөн болон бусад өргөдөл, хүсэлтийг цаг тухайд нь шийдвэрлэдэг байна. Хүснэгтэд харуулснаар 100 хувь шийдвэрлэсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- 1-р курст шилжиж буй оюутнуудад заах ерөнхий эрдмийн хичээлийн агуулгыг мэргэжлийн ур чадвартай ойртуулж төлөвлөх

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

5.1 Багшийн сонгон шалгаруулалт, албан тушаал, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- *Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлого: Сонгон шалгаруулалт, хөгжүүлэлт, төлөвлөлт, хэрэгжилт*
- Тус сургуулийн хүний нөөцийн бодлого нь СУИС-ийг 2012-2021 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө, Соёл урлагийн их сургуулийн захирлын А/147 тоот тушаалаар баталсан дүрэм, тэнхимд тавигдах шаардлага, профессор багш ажиллуулах журам зэргийг тус тус үндэслэдэг.

- Багшийн албан тушаалын зэрэглэлд тавигдах шаардлага нь СУИС-ийн 2015 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн А/147 тоот тушаалаар шинэчлэн найруулсан дүрэм, журмуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгодог.
- Багшийн сонгон шалгаруулалтыг Монгол улсын хөдөлмөрийн тухай хууль, тухайн сургууль, хөтөлбөрт тавигдах шаардлага, профессор багш ажиллуулах журмыг үндэслэн нээлттэй ажлын байрны сонгон шалгаруулалтыг зарлан чадварлаг боловсон хүчнийг авдаг.
- Багшийн сонгон шалгаруулалтыг хичээлийн жилд 1-2 удаа зохион байгуулдаг. Багшид тавих ерөнхий шаардлагыг хангасан иргэнийг үндсэн багшаар авч ажиллуулахаас гадна өндөр мэргэжлийн эрдэмтэн, нэр хүндтэй улсын алдар цолтонг сонгон шалгаруулалтгүйгээр авч ажиллуулдаг журамтай. Тиймээс өндөр ур чадвартай уран бүтээлч, профессор, судлаач багш нарыг урилгаар, гэрээт багшаар ажиллуулж байна.
- Багшийн хөгжил хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлснээр багшийн мэргэжлийн болон хувь хүний ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, хөтөлбөрийн чанарыг сайжруулах нэг алхам болж байна.

- *Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин*

Зураглаач мэргэжлийн багш нарыг бусад ижил төрлийн тухайн салбар, чиглэлдээ олон жил ажилласан, уран бүтээлийн туршлагатай шилдэг тэргүүний уран бүтээлч байх шалгуурыг гол болгож ажиллуулдаг онцлогтой. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлж буй тухайн салбарын зөвлөх, тэргүүлэх зэрэглэлийн уран бүтээлчдээс Л.Шаравдорж, Б.Донров, Ц.Туяа, Д.Пүрэвдорж, Д.Давааням нар хичээл зааж байна. Зураг авалт хөтөлбөрт хичээл заадаг 10 багшаас Төрийн соёрхолт 1, Монгол улсын соёлын гавъяат зүтгэлтэн 2, доктор 2, магистр 4, бакалавр 3 багш байгаагаас 2 багш нь дэд профессор, 1ахлах багш, багшийн орон тоонд 7 багш ажилладаг. Хөтөлбөр нь докторын зэрэгтэй 1 багштай.

- *Багш суралцагчдын тооны зохистой харьцаа*

2012-2017 оны хооронд нэг багшид ногдох оюутны тоо улсын стандартыг хангаж байна. 2012 онд 18, 2013 онд 15, 2014 онд 16, 2015 онд 15 байна.

- *Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд шаардлагыг мөрддөг байдал тавигдах шаардлагыг мөрддөг байдал*

Багш нарын хэрэгжүүлж буй эрдэм шинжилгээ, инноваци, сургалт, уран бүтээлийн ажлын туршлага, үр дүнгээс хамаарч, профессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагажигч багш гэсэн 5 шатлалтай албан тушаал дээр хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байна.

- *Гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилан багш нарыг урамшуулдаг байдал*

Тус сургуулийн үйл ажиллагааны үр дүнг “Багш-тэнхим-профессорын баг-Бүтцийн сургууль-СУИС” гэсэн бүтэцтэйгээр үнэлдэг. Сургалтын үйл ажиллагааны үр дүнг “Багш-тэнхимийн эрхлэгч-Бүтцийн сургуулийн сургалтын алба-бүтцийн сургуулийн захирал-сургалтын бодлого зохицуулалтын газар” бүтэцтэйгээр үнэлдэг. Эрдэм шинжилгээний ажлын үр дүнг “Багш-эрдэмтэн нарийн бичгийн дарга-эрдэм шинжилгээ, инновацийн газар” , уран бүтээлийн ажлын үр дүнг “Багш-уран сайхны удирдагч-уран бүтээлийн газар” гэсэн сургуулийн удирдлагын босоо тогтолцооны түвшин бүрээр үнэлж, хянат тавьж ажилладаг. Дээрх шаталсан тогтолцоогоор профессор багш, ажилтан, ажилчдын ажлын үр дүнг улирал тутам дүгнэж, нэг сард үндсэн цалингийн 10 хүртэл хувиар үр дүнгийн нэмэгдэл олгох журмыг 2013 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс батлан мөрдөж байна. 2017 оны 1 дүгээр сараас эхлэн ажлын үр дүнг 2 сар тутамд үнэлж, 3 дах сарын цалин дээр нэг сард үндсэн цалингийн 5-10 хувиар тооцон, үр дүнгийн урамшуулал олгож эхэлсэн байна.

Уран бүтээлийн үйл ажиллагааг сайжруулах үүднээс бүтцийн сургуулийн уран сайхны удирдагчдыг үндсэн цалингийн 20-40 хувиар хавсран ажиллуулж байгаа.

Шилдэг багш нарыг 4 номинациар шалгаруулдаг бөгөөд тус хөтөлбөрийн хүрээнд 2014-2017 оны хооронд 4 багш шилдэг уран бүтээлч, шилдэг сурган хүмүүжүүлэгч багшаар шагнагдсан байна. Гадаад дотоодын сургалтанд хамрагдах тохиолдолд сургуулиас тодорхой хөрөнгийг тооцож гаргадаг бөгөөд энэ урамшуулалд багш Д.Давааням Австрали улсад гэрэл зураг авалтын 2 сарын сургалтанд хамрагдаж, энэ сургалтанд хийсэн бүтээлээрээ 2017 оны “Акийн шилдэг гэрэл зурагчин” өргөмжлөлийг авсан нь багшийг хгжүүлэх, урамшуулах бодлого амжилттай хэрэгжиж байгаагийн нэг жишээ болно.

Уг хөтөлбөрийн хүрээнд багш нарт олгосон урамшуулал, тэтгэлэгийн хэмжээ 2012-2017 оны хооронд 12 сая төгрөгөөс 32 сая төгрөг болтол нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Мэргэжлийн өндөр ур чадвартай уран бүтээлч, судлаач багш нарыг урилгаар, гэрээт багшаар ажиллуулдаг.
- Багшийг урамшуулах төрөл, хэмжээг нэмэгдүүлсэн. Шилдэг багшаар шалгарсан багш нар уран бүтээлээрээ нээлттэй үзэсгэлэн гаргадаг, мөнгөн урамшуулал авдаг.

Анхаарах асуудал:

- Доктор зэрэгтэй багшийн тоог нэмэгдүүлэх
- Багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл туурвих ажлыг эрчимжүүлэх

5.2 Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- *Багшийн мэргэжил; заах арга зүйн ур чадвар; эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн түвшин; суралцах хэрэгцээг тодорхойлох судалгааг тогтмол хийдэг байдал*

Багшийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд багшийн эрдэм шинжилгээ, судалгааны үр дүн, заах арга, ур чадварт оюутны сэтгэл ханамжийн судалгааг авч, түүнд үндэслэн урт богино хугацааны сургалтад хамруулдаг. Тухайлбал, хичээл зааж буй багшийн талаархи сэтгэл ханамж хангалттай 39.5 буюу чанарын үнэлгээ 4.03, ерөнхий эрдмийн хичээлийн заах арга зүйд хангалттай 38.3 буюу 3.66, хичээл хоорондын уялдаа холбоонд хангалттай 38.4 буюу 3.40, нийт чанарын дундаж үнэлгээ 3.70 гэсэн судалгааны дүн гарсан байна. Эндээс харахад сургалтын технологи нь тэдний бүтээлч үйл ажиллагаанд тулгуурласан үр өгөөжтэй, хөтөлбөрийн хичээл хоорондын уялдаа холбоог хангасан, хичээл зааж буй багшид сэтгэл ханамжтай гэдэг нь харагдаж байна.

- *Багшийн хөгжлийн хөтөлбөр, хэрэгжилт, дүн шинжилгээ, сайжруулалт*

Багшийн хөгжлийг дараах үндсэн 2 байдлаар төлөвлөж ажилладаг. Үүнд:

1. Багш нарын мэргэжлийг дээшлүүлэх, чадваржуулах, ахмад багш нарын залуу халааг бэлтгэх талаар 13 зорилтыг төлөвлөн, ажиллаж байна.
2. Багшийн хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудлаар 7 зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

- *Багшийг үе шаттай хөгжүүлж, урт богино хугацаанд мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлж чадавхжуулдаг байдал*

Багшийг тасралтгүй хөгжүүлэх зорилгоор “Багшийн хөгжил хөтөлбөр”-ийг боловсруулж, шат дараатай амжилттай хэрэгжүүлж байна. Тухайлбал, гадаад хамтын ажиллагаатай байгууллага, их дээд сургуулиудаас багш, уран бүтээлчдийг урьж ажиллуулан, богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг зохион 2012-2016 онуудад нийт 16 удаа зохиож сургалтад бүх багш нараа хамруулжээ. /Сургалтын зураг, тайлан /

- *Гадаад, дотоодод туршлага судлуулсан байдал*

Сүүлийн жилүүдэд бүрэлдэхүүн сургуулиас багш нарыг гадаадад мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг тусалцаа үзүүлж байгаа бөгөөд үүний үр дүнд сургалтад хамрагдагч багш нарын тоо өссөн байна. Үүнд, дээд боловсролын шинэчлэл, багшийн

хөгжил, зураглаачийн мэргэжил дээшлүүлэх, туршлага солилцох чиглэлээр ХБНГУ, БНХАУ, Австрали улсуудад 7 багшийг 14 хоногоос 2 сарын хугацаатайгаар сургалтад хамруулсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшид 1 сараас 1 жилийн хугацаатай бүтээлийн чөлөө, эрдмийн зэрэг цол хамгаалсан багшид урамшуулал олгодог. Мөн багш нарын амрах өрөөг тохижуулсан.

Анхаарах асуудал:

- Оюутнуудаас авсан судалгаанаас харахад хамгийн доогуур үнэлгээ авсан асуулт нь хичээлд хэрэглэх ном сурах бичиг, гарын авлага хүрэлцээтэй гэдэгт 10-25 хувь нь хангалтгүй үнэлгээ өгсөн байгаа тул сургуулийн зүгээс энэ тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй.

5.3 Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- *Захиалгат төсөл, гэрээт ажилд оролцсон байдал*

СУИС-ийн болон бүрэлдэхүүн сургуулиудын хэрэгжүүлж буй төсөлд хамгийн өргөнөөр оролцдог. 2013-2017 оны хооронд 25 төсөлд 10 багш, нийт оюутнууд хамрагдсан байна. Эдгээр төслүүд нь Германы Урбан номадс төсөл, “Боинг боинг” жүжиг бичих ТУС-ийн төсөл, НҮБ-ын бүтээлийн төсөл, дамжуулах үг төслөөс гадна баримтат кино хийх, соёлын наадмын цуврал нэвтрүүлгүүд, элсэлтэнд зориулсан видео шторк, улсын хэмжээний гэрэл зургийн уралдаан зохион байгуулах гэх мэт олон ажлуудыг хийж амжилттай хийж, гүйцэтгэжээ.

- *Судалгааны ажлын үр дүнгээр хөтөлбөрийн сургалтын агуулга, арга зүй; судалгааны ажил шинэчлэгдэн хөгжсөн байдал*

Багшийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд сургалтыг уран бүтээлтэй холбон ажиллах зорилгоор судалгааны олон чиглэлд төсөл, хөтөлбөр, гэрээт болон захиалгат ажлуудыг гүйцэтгэж байна. Эдгээр ажлын хүрээнд багш нарын мэдлэг, мэдээлэл, гадаад харилцаа хөгжих, оюутнуудын дадлагажих, онолын мэдлэгээ практикт бататган, уран бүтээл болгон хувиргах, гадаад хэлний мэдлэгээ сайжруулах зэргээр тухайн хөтөлбөр өөрөө өөрийгөө хөгжүүлэх нөхцөл бүрэлдэж байна. Үйлдвэрлэлийн дадлага, эрдэм шинжилгээ, судалгаа, уран бүтээлийн ажил хийх бааз суурь сайжирсан, дадлага хичээлүүдийн багц цаг нэмэгдсэн нь хөтөлбөрийн чанар сайжрахад ахиц дэвшлийг өгч байна.

- *Үндэсний болон олон улсын нэр хүндтэй хэвлэлд нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн байдал*

Жил бүр багш, оюутны эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулдаг. Гэвч эрдэм шинжилгээний өгүүллэг, олон улсад төдийгүй өөрийн улсад ч цөөхөн хэвлүүлсэн байгаа тул 2017 оноос эхлэн багш, ажилтантайгаа эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг чанаржуулах, эрдмийн зэрэгтэй багшийн тоог нэмэгдүүлэхэд санаачилгатай ажиллуулах зорилгоор нэмэлт гэрээг шинээр хавсран хийж ажилладаг. Багшийн эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцуулахад анхаарах шаардлагатай байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2013-2016 онуудад 5 номыг сургуулийн төсвөөс санхүүжүүлж, мэргэжлийн сургалтын хэрэглэгдэхүүнтэй болсон.
- Залуу багш нарын кредитийн тодорхой хувийг уран бүтээлээр тооцох журам боловсруулах ажил эхний шатандаа явж байгаа.

Зөвлөмж:

- Мэргэжлийн ном, сурах бичгийн төрөл, тоог олшруулах, уншлагын танхимтай болох
- Шинжлэх ухаан боловсролын болон уран бүтээлийн шинэ туршилт, инноваци, патентын эрхтэй болох

5.4 Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Үзүүлэлт нотолгоо:

- *Өөрийн үнэлгээний тайлан*

Зураг авалт хөтөлбөрийн багш нар жил бүр ажлын тайлангаа тэнхимд гаргаж өгдөг бөгөөд үүний дагуу багш нарын жилийн ажлын үр дүнг тооцдог. Харин 2011-2012, 2014-2015 онуудад багш нарын аттестатчлал явуулж, өөрийн үнэлгээний тайланг хийсэн. СУИС-аас гаргасан шийдвэрийн дагуу ахмад болон дадлагажигч багш нараас өөрийн үнэлгээний тайланг аваагүй боловч багш нарын нэмэгдэл хөлс тооцохдоо өөрийн үнэлгээг 3 үзүүлэлтээр 100 хүртэл оноогоор дүгнэдэг. Үүнд,

- Ажлын байрны тодорхойлолтоор хүлээсэн үүргийн биелэлт, хөдөлмөрийн дотоод журам, ёс зүйн дүрмийн биелэлт
- төлөвлөгөөнөөс гадуур хийгдсэн ажил
- Сургууль хөгжүүлэхэд оруулсан хувь нэмэр эдгээр үзүүлэлтээр дүгнэдэг байна.

- **Багшийн хөндлөнгийн үнэлгээ /Аттестатчлал, эрэмблэлт, чансаа тогтоолт/**

Тус сургуулийн зорилго зорилт нь “Сургалт-эрдэм шинжилгээ-уран бүтээл, бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагаа”-г “Төлөвлөлт-хэрэгжүүлэлт-хяналт-сайжруулалт” гэсэн үе шаттайгаар хэрэгжүүлж байгаагийн нэг ажил нь дотоод хяналтын ажил юм. 2012-2016 онуудад дотоод хяналт-мониторингд нийт 33 багш хамрагдсанаас “Зураг авалт” хөтөлбөрт хичээл заадаг 25 багш байна. Энэ ажлын хүрээнд багш нарын цагийн тооцоонд 2 удаа, багш нарын зааж буй хичээлийн хүрээнд улиралд нэг удаа оюутнуудаас санал асуулга авч, үйл ажиллагааг үнэлж, дүгнэдэг байдлыг тогтмолжуулсан байна. Мөн шалгалтаар илэрсэн зөрчлийг сургуулийн захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн, шийдвэрлэдэг.

СУИС-ийн багшийн аттестатчлах журмын дагуу 2011-2012 онд 11 багш, 2014-2015 онд 16 багшийг хамруулсан бөгөөд багшийн аттестатчлалын дундаж оноо 450 байснаа 765,50 болж өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь сургуулиас багш нараа хөгжүүлэх, эрдэм шинжилгээний хуралд хамруулах, бүтээл туурвихад нь тодорхой дэмжлэг үзүүлдэг болсон зэрэг ажил ихээхэн нөлөөлсөн гэж СУИС-ийн сургалт, эрдэм шинжилгээ, инновацийн газраас дүгнэсэн байна.

- Сургалтад ашиглаж буй сургах/заах аргын үр дүн, үр нөлөөний судалгаа
- Тайлан, судалгааг хэлэлцэж, дүгнэлт гаргасан байдал

Сургалтаа радио, телевизийн боловсон хүчин, материаллаг баазад тулгуурласан давуу талаа ашиглан, дадлага давамгайлсан прагматик сургалтын арга зүйгээр шинэчлэн, зохион байгуулж байна.

Сургалтын явцад олж авсан мэдлэгээ баталгаажуулах, уран бүтээлч эрэл хайгуул хийх зорилгоор үзэсгэлэн, тайлан тоглолт, зохион байгуулдаг нь хөтөлбөрийн зарим хичээлийг багаар бүтээл хийлгэн дүгнэх аргыг ашиглаж байгаагаас харагдаж байна.

СУИС-ийн багш нарын ажлын дүнг өөрийн үнэлгээний тайланг үндэслэн дүгнэлт өгөхөөс гадна аттестатчлалд оруулж дүгнэдэг. Аттестатчлалын үр дүнгээр цалин хөлсийг ахиулах гол шалгуур болгон авч үздэг.

- **Сургалтад оролцогчдоор багшийг үнэлүүлэх**

Сургалтын процессыг тасралтгүй үе шаттайгаар сайжруулж, боловсронгуй болгоход хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх, нээлттэй байх зарчмыг баримталж, багшийн хөгжлийг дээшлүүлэхэд суралцагчдын багшийг үнэлсэн судалгааг тогтмол хийж байна.

- **Багшийн бүхий л үйл ажиллагааны баримт, материал**

Багшийн үйл ажиллагааны баримт материалд дараах зүйлс багтдаг. Үүнд:

1. Заадаг хичээлийн сургалтын төлөвлөгөө, стандарт
2. Заадаг хичээлийн иж бүрдэл / конспект, гарын авлага, ашиглах бусад нэмэлт материал/
3. Е хичээлийн иж бүрдэл
4. Журнал

5. Үйл ажиллагааны төлөвлөгөө
6. Стратеги төлөвлөгөө зэрэг орно.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутнуудаас авсан судалгаанаас харахад сургалтын технологи нь бүтээлч үйл ажиллагаанд суурилсан, үр өгөөжтэй, бие даан ажиллах боломжийг бүрдүүлсэн, хичээл хоорондын уялдаа холбоо сайн тул багшид сэтгэл ханамжтай гэсэн дүн гарсан.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

6.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- *Оролцогч болон сонирхогч талуудын эрэлт хэрэгцээ ба агуулгын харьцуулсан шинжилгээ*

Уг хөтөлбөрийн хувьд эрэлт хэрэгцээг тодорхойлох анхан шатны нэгж нь хөтөлбөрийн сонирхогч талууд болох ажил олгогч, төгсөгчид, мэргэжлийн байгууллагууд байна. Эдгээр сонирхогч талуудаас судалгаа, уулзалт ярилцлага хийх замаар хөтөлбөрийн эрэлт хэрэгцээ, мэргэжилтэнд тавих шаардлагыг тодорхойлдог болох нь судалгааны дүн, тайлан, уулзалтын зурагаас нотлогдож байна. Судалгааны үр дүнгээс гарсан шийдвэр, дүгнэлтийг үндэслэн хөтөлбөрийн агуулга, сургалтын хөтөлбөрт өөрчлөлтийг хийхдээ мэргэжлийн багш нарын оролцоотойгоор хөтөлбөрийн хороонд шийдвэр гаргаж, эрдмийн зөвлөлд оруулдаг байна. Хөтөлбөрийн хэлэлцүүлгийг 2012 оноос эхлэн 5 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Тухайлбал, 2014 онд ЗУЧ- 1, 2, 3, 4 хичээлийн хөтөлбөрийг хэлэлцүүлэн дахин боловсруулж батлуулсан, 2015 онд хэлэлцүүлгийг оролцогч талуудын дунд зохион байгуулан үүний үр дүнд эвлүүлгийн онол 2кр, уран сайхны гэрэлтүүлэг 2кр-ийн хичээлүүдийг тус тус нэмж оруулсан байна.

- *Сургалтын агуулга нь хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцсэн байдал*

СУИС-ийн сургалтын төлөвлөгөөг боловсронгуй болгох зорилгоор “сургалтын хөтөлбөрийн замын зураглал боловсруулах” төсөлд амжилттай оролцсон. Энэ

төслийн хүрээнд 2011 оноос эхлэн Uniculture системд оруулсан хөтөлбөрийн бүх хичээлийн тодорхойлолтууд дээр анализ хийж агуулга давхардал арилгах, хичээлийн код, багц цагийг дахин нягталж хичээлийн тодорхойлолт, зорилгуудыг дахин шинэчилж ажилласан нь сайшаалтай байна. Хөтөлбөрийн хүрэх үр дүнг зураглаачийн мэргэжлийн онолын суурь мэдлэг, мэргэжлийн ур чадвар, хувь хүний харилцааны болон багаар ажиллах ур чадвартай байхаар ерөнхийлөн тодорхойлсон байна. Хүрэх үр дүн нь хөтөлбөрийн зорилго, зорилуудтай нийцэж байна. Гэсэн хэдий ч хөтөлбөрийн хүрэх үр дүнг хэт ерөнхийлөн гаргасан нь дутагдалтай харагдаж байна.

- *Суралцагч хичээл, багшийг сонгон суралцдаг байдал чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.*

Уг сургууль нь 2011 оноос эхлэн кредит системд бүрэн шилжсэн төдийгүй оюутан бүр багш, хичээлийг сонгон суралцах боломжтой нь Uniculture программаас харагдаж байна. Хичээл сонголт хийхдээ багшийг чөлөөт хэлбэрээр сонгодог боловч анги дүүргэлтээс хамаарч өөр багшийг сонгохоос өөр боломжгүй тохиолдол гардаг бэрхшээлтэй. Хичээлийг сонголт 1-ээр хийж, сонголт 2-оор сонгох хичээлээ баталгаажуулдаг. Хичээл сонголтыг хийсний дараа хичээлийн хуваариа сонгож, чөлөөт сонголт, төлөвлөлтийг хийдэг болсоноор оюутан 3.5 хүртэлх жилийн хугацаанд суралцаад төгсөх боломжийг бүрдүүлсэн нь сайшаалтай байна.

- *Хөтөлбөр дэх хичээлийн хэлбэр, онол, практикийн зохистой харьцааг хангасан байдал*

Хичээлийг удирдан явуулахдаа төсөл, кейс-д суурилах зэрэг орчин үеийн шавь төвтэй болон уламжлалт сургалтын хэлбэрийг хослуулан хэрэглэдэг бөгөөд “Дамжуулах үг” төсөл хэрэгжүүлэн ахмад багш, мэргэжлийн алдартай зураглаачдаар мэргэжлийн ангийн оюутнуудад зориулсан видео дүрст е-хэлбэрийн хичээлийг бэлтгэсэн байгаа сайн тал болж байна. Ялангуяа эдгээр хичээлүүд нь онол практик хослуулсан сайн чанартай хичээл болох нь харагдаж байна. Үндэсний болон олон улсын хэмжээнд мэргэжлээрээ ажиллаж байгаа алдартай зураглаачдыг урьж “Мастер класс” хэлбэрээр хичээлийг явуулдаг нь илүү бодит, практикаас суралцах боломжийг оюутнуудад олгож байгаа харагдсан. Мэргэжлийн хичээлийн хувьд ашиглах техник төхөөрөмжийн хувьд хангалттайн дээр оюутан бүр дадлага хийхэд хүрэлцээтэй сайн анги, лабораториудаар хангагдсан байна.

- *Үйлдвэрлэл, практик, клиник сургалтын агуулгыг хамтран хэрэгжүүлдэг байдал*

- Хөтөлбөрийн хувьд зарим хичээл хооронд багаар хамтран ажиллах шаардлгатай болдог. Тухайлбал, телевизийн продакши хичээлийн найруулах урлаг, зураг авалт, сэтгүүлзүй, радио телевизийн хөтөлбөрийн оюутнууд нэг баг болон хамтран ажиллаж уран бүтээл хийдэг нь оюутнуудыг багаар ажиллах, бие биенээсээ суралцах боломжийг олгож байдаг.

- ОХУ болон Шанхайн ижил мэргэжлийн сургуультай хамтарсан гэрээ байгуулан ажилладаг. Үйлдвэрлэлийн болон сургалтын дадлагыг Шанхайд 7-21 хугацаатай хамтарсан байдлаар хийдэг.
- Солонгосын Кино урлагийн их сургуультай хамтарч ажилладаг.
- Үндэсний хэмжээнд танилцах дадлагыг Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа тогтмол 4 телевизтэй хамтран ажилладаг бусад телевизид оюутнуудын бүтээлийг гаргадаг.
- Хамтарсан нэвтрүүлэг хийдэг, “Үд дундын Монгол” нэвтрүүлэг хийж байсан.
- Дадлагын хугацаа нь зун байсан боловч энэ талаар судласан судалгааны үндсэн дээр дадлага хийлгэх газрын хэрэгцээний судалгааг гаргаж өвлийн улиралд хийх хэрэгтэй гэдгийг тодорхойлсон байна.

- *Зайны болон цахим хичээлүүдийг E- контент түвшинд боловсруулан сургалтад ашигласан байдал*

СУИС-ийн хөтөлбөрийн стратегийн зорилтын 3-р зорилтод сургалтын агуулга, технологи, стандартыг төгөлдөржүүлэх талаар тусгаж түүнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд E- сургалтын зохион байуулахад шаардлагатай дүрэм журмыг шинэчлэх, техник технологийн нөөцийг бүрдүүлэх, шаардлагатай програм хангамжуудыг нэвтрүүлж хэрэгжүүлэх талаар анхаарч ажиллаж байна. Уг хөтөлбөрийн хувьд зарим хичээлийг төлөвлөгөөний дагуу video, e хичээлийн хэлбэрт оруулан бэлтгэж байна. Жил бүр цахим хичээлийн тоог нэмэгдүүлэхэд анхааран ажиллаж байгаа нь баримтаар нотлогдсон. Тухайлбал, гэрэлтүүлгийн үндэс хичээлийг видео хичээл болгосон нь олны таашаал хүртэж байгаа талаар мэргэжлийн багш нар ярьж байсан.

- *Хичээл хоорондын уялдаа, залгамж холбоог хангасан байдал*

Хичээлийн залгамж холбоог хангахад анхаарч байгаагийн дээр хичээл хоорондын олгох ур чадварын хамтын ажиллагааг хангаж байгаа нь энэ хөтөлбөрийн нэг давуу тал байна. Тухайн хөтөлбөрөөр суралцагчийн мэргэжлийн ур чадваруудын уялдаа холбоог сайн хангаж байна. Тухайлбал, 3-4 хичээл хамтран нэг төсөл хэрэгжүүлж, хамтын бүтээлийг хамгаалуулах замаар дүгнэдэг нь мэргэжлийн ур чадварын уялдаа холбоог хангахад чухал ач холбогдолтой байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрөөр эзэмших үр дүнтэйгээ холбогдож уялдаа холбоо бүхий хичээлүүдийн хамтын бүтээл гаргах төсөлд суурилсан сургалтын арга, үнэлгээг хэрэгжүүлдэг нь оюутнуудыг системтэй хандах, бүтээлч хандах сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэгдсэн үр дүнтэй сургалтын арга, үнэлгээний хэлбэрийг ашигладаг байна.
- Хичээл бүр нь төсөл, үйлдвэрлэл бүтээлд суурилж явуулдаг нь үр бүтээлтэй практик мэдлэг, ур чадвар олгоход чиглэгдсэн байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн оролцогч (Ажил олгогч, төгсөгчид, оюутан) талуудыг хөтөлбөрийн хороо бусад сайжруулах асуудлаар хамруулалт нь хангалттай бус зөвхөн судалгаа авах байдлаар гаргаж байгаа нь учир дутагдалтай байна.
- Хичээлээр олгох мэдлэг ур чадварыг үнэлэх арга зүйг ерөнхий байдлаар тусгасан ирц 30 хувь, идэвхи 15 хувь, явц 25 хувь, шалгалт 30 гэх мэт хичээл бүр харилцан адилгүй дүгнэхээр заасан байна.

6.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- *Сургалтын арга зүйг боловсруулсан баримт бичиг, загвар*

Боловсруулсан сургалтын хөтөлбөрөөс харахад сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, суралцагч төвтэй, мэдээлэл харилцааны дэвшилтэт технологи ашигладаг. Хөтөлбөрийн сургалт нь идэвхтэй сургалтын арга зүйг ашигладаг шавь төвтэй сургалтын заах арга, хэлбэрүүдийг хэрэглэдэг нь сургалт явуулж буй байдал, багш, оюутнуудын төлөөлөлтэй хийсэн уулзалтаас харагдаж байна.

- *Сургалтад ашиглаж буй арга зүй нь мэдлэг бүтээлгэж, хэрэглэж сургахад чиглэсэн байдал*

Зураг авалт хөтөлбөрийн үндсэн баримт бичигт төлөвлөсөн арга зүйтэй уялдсан бөгөөд сургалт явуулах арга хэлбэр нь уламжлалт, шавь төвтэй, бүтээлч сэтгэлгээ хөгжүүлэх арга зүй дээр үндэслэн явагддаг. Эдгээр нь олгох ур чадвар, мэргэжлийн хичээлийн онцлогоос хамааран дээрх гурван аргыг хослуулан хэрэглэдэг байна. Тухайлбал, лекцийн сургалтын үед хэрэглэх арга нь уламжлалт аргыг хэрэглэдэг боловч цахим технологи ашиглан лекцийг google classroom-д байршуулан онолын мэдлэгийг өгч, тухайн онол мөн чанарыг ойлгоход лекцийг бага бүлгээр ярилцлага хэлбэрээр явуулах нь тэдний оролцоог нэмэгдүүлдэг талаар багш, оюутнууд ярилцлагадаа онцлон дурьдаж байна. Харин дадлага, семинарын хичээлийг асуудал шийдвэрлэх, практик амьдрал дээр суурилсан явуулдаг нь сайшаалтай байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн дүүрэн, үнэлдэг арга зүйтэй, түүнийг байнга сайжруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

Мэдлэг, ур чадвар, хандлагын түвшин тогтоох, ахиц дэвшлийг үнэлэх үнэлгээний арга, аргачлал, хэрэглээ

- Оюутны мэдлэгийг үнэлэхдээ ирц, идэвхи, бие даалт, лабораторийн ажил, явцын сорил I, II, улирлын шалгалт гэсэн үзүүлэлтээр дүгнэдэг бөгөөд хувь хүний ур чадварыг үнэлэхдээ рубрикийн аргыг хэрэглэдэг.
- Оюутны мэдлэгийг үнэлэх аргачлалын талаар оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгааг авч өөрсдийн дутагдалтай талыг шүүн хэлэлцэж байдаг нь сайшаалтай.
- *Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл нэг бүрийн үнэлгээний арга, хэлбэр нь суралцагчдыг тасралтгүй хөгжихөд хөтөлдөг, ил тод найдвартай, шудрага, ижил тэгш зарчмыг хангасан байдал*
- Үнэлгээний арга хэлбэр нь хичээлийн онцлогоос хамааран өөр байх ба мэргэжлийн түвшинд ур чадвар эзэмшилт, онолын мэдлэг ур чадвараа хамтад рубрикийн арга ашиглан үнэлнэ. Тухайлбал, нэг төслөөр 4 хичээлийн дүн гаргах боломж байдаг.
- Оюутны хичээлийн үнэлгээ нь олон багшийн үнэлгээгээр ил тод шудрага болдог талаар оюутнуултай хийсэн уулзалтаас нотолж байсан. Харин багш нар оюутны мэдлэг, ур чадварыг хэрхэн үнэлдэг талаар авсан судалгааны үр дүнгээс харахад судалгаанд оролцсон оюутнуудын 77.5 хувь нь сэтгэл ханамжтай, 22.5 хувь нь сэтгэл ханамж муу гэж хариулсан байна. Хөтөлбөрийн хувьд сэтгэл ханамж нь муу байгаа хэсэгт анхаарч ажилладаг талаар ярилцаж байсан.
- *Суралцагчийн гаргаж буй амжилтууд*
- СУИС нь суралцаж байгаа оюутнуудынхаа мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд ихээхэн анхаардаг бөгөөд мэргэжлийн тэмцээн уралдаанд оролцоход нь урамшуулах, холбогдох зардлыг нь гаргадаг байна. Ингэснээр мэргэжлийн хувьд ур чадвар нь өсөхөд бодит дэмжлэг болж байгаа нь харагдсан.
- Суралцагчдын бүтээлээр үндэсний болон олон улсын хэмжээнд амжилттай оролцдог байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө

7.1. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Үзүүлэлт нотолгоо:

Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, ажлын байрны нийцлийн судалгааг тогтмол явуулж, хөтөлбөрийн шинэчлэлд тусгаж хэрэгжүүлдэг байдал

- 2011 оноос хойш 3 жилд нэг удаа төгсөгчдөөс судалгаа авсан. Судалгааны үр дүнгээс харахад 81.3 хувь нь ажлын байраар хангагдаж ажиллаж байна.
- Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа 7 телевизийн нийт 40 орчим ажил олгогчдоос төгсөгчдийн мэргэжийн ур чадвар, техник технологийн мэдлэг, багаар ажиллах чадвар, бүтээлч сэтгэлгээ, асуудлыг шийдвэрлэх чадвар зэрэгт үнэлгээ авахад “сайн” гэсэн үнэлгээг өгсөн байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хичээлийн хөтөлбөр нь ажлын байрны хэрэгцээ шаардлагын дагуу нэмэгдэж байдаг нь ажиглагдсан.
- Хөтөлбөрөөр төгсөгчийн карьерийн өсөлтийн судалгааг гаргадаг.

РТМУС-ийг Зураглаачаар төгсөгчдийн карьерийн өсөлтийн судалгаа

№	Нэр	Албан тушаал
1	С.Отгонжаргал	МҮОНРТ-ийн Зураглаачдийн албаны дарга МУСТА, РТТА, ХМТА
2	Ж.Нямсүх	МҮОТ-ийн Ахлах зураглаач МУСТА, РТТА, ХМТА, Азийн телевизүүдийн холбооны шагналт
3	Б. Чинбат	МҮНОТ-ийн зураглаач МУСТА, РТТА
4	М.Төрманлай	Вест студийн захирал
5	Д.Энхтөр	ТВ4 телевизийн уран сайхны удирдагч
6	Г.Дүгэржав	Тагнуулын Ерөнхий Газар ХМ-ийн албаны дарга
7	Г.Тэмүүжин	Оргил” ХХК-ийн ХМА-ны дарга
8	Ц.Тайван	Гадаад Харилцааны яамны ХМА-ны дарга
9	Д.Тэмүүлэн	“Fine Art” студийн захирал
10	Д.Давааням	“Батзориг сан”-ийн тэргүүн, Азийн шилдэг зураглаач
11	Үнэнбаяр	ТВ9 телевизийн зураглаачийн албаны дарга
12	Д.Содном	“Чингис хаан” студийн захирал
13	Ү.Алтанбагана	MNC телевизийн зураглаачдын албаны дарга
14	Ц.Алтанхуяг	УИХ-ын Тамгын газарт мэргэжилтэн
15	Б.Батпүрэв	Дорноговь аймгийн телевизийн зураглаачдын албаны дарга
16	Д.Ванчинцогзол	MN2 зураглаачдын албаны дарга
17	Д.Батмөнх	Студийн захирал
18	Ц.Дэлгэрзаяа	БГД-ийн төслийн менежер
19	П.Түвшин	Вест студийн захирал
20	Ш.Уянга	Сentry land маркетингийн менежер
21	Д.Болдбаатар	МҮОНТ-ийн кино албаны дарга
22	О.Ганбат	Гэрүүд студийн захирал
23	Б.Анхбаяр	Төв аймгийн “Зуун мод” телевизийн дарга
24	М.Сүхбат	ТМ телевизийн зураглаачийн албаны дарга
25	О.Хүрэл-Очир	HD Монгол телевизийн зураглаачдын албаны дарга
26	Н.Батбаяр	NT телевизийн зураглаачдын албаны дарга
27	Х.Даваадорж	ЗГХА “Гэр бүл хөгжлийн газар” ТГ-ын мэргэжилтэн
28	Ж.Золзаяа	Сүхбаатар аймгийн СБ телевизийн ахлах зураглаач
29	Х.Өнөрбаясгалан	БОЯ-ны Студийн захирал
30	Б.Анхбаяр	Баянхонгор аймгийн төв теледизийн дарга
31	Г.Гүнбаатар	“Фонтакстик” продакшны ерөнхий зураглаач

Анхаарах асуудал:

- Судалгаа хийгдсэн баримт материал дээр огноо байгаагүй нь нотлох баримт болохгүй ба цаашид заавад огноотой байлгах.
- Төгсөөд ажлын байртай болох хүртэлх хугацааг тодорхойлох нарийн судалгаа авагдаагүй байгааг анхаарах.

7.2. Хөтөлбөрийн үр нөлөө:

Хөтөлбөр үр дүнгээ үнэлүүлэх, үнэ цэнээ тодорхойлох, ахиц дэвшлээ харуулах нотолгоотой байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй 170 гаруй телевиз, кино продакшн болон бусад соёл урлагийн бүхий л салбарт 300 гаруй төгсөгчид нь зураглаач, продюсер, мэргэжлийн гэрэл зурагчин, нэвтрүүлгийн программ төлөвлөгч, эвлүүлэгч, уран сайхны киноны эвлүүлэгч, нэвтрүүлгийн маркетингийн менежер, сонин сэтгүүлийн гэрэл зурагчнаар амжилттай ажилладаг бөгөөд тэдний өдөр тутмын сайхан нэвтрүүлэг, кино бүтээл нь ард түмний хүртээл болж байгааг бид харж болно. Тухайлбал, 2006 онд “Сарны нулимс” олон ангит киноны ерөнхий зураглаачаар 1998 оны төгсөгч Ж. Нямсүх, 2016 онд гарсан “Хайрын клуб” уран сайхны киноны зураглаачаар 2016 оны төгсөгч Д.Нямдорж ажилласан байна.
- Монгол улсын соёл урлагийн салбарт 831 байгууллага үйл ажиллагаа явуулж, 6813 ажиллагсад ажиллаж байгаа нь 2014 оны байдлаар ДНБ-ны 0.4%-ийг бүрдүүлж, улмаар энэ салбарын эзлэх хувь өсөж байгаа нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ нэмэгдэж байгааг харуулж болох талтай гэж дүгнэсэн байна. Мөн түүнчлэн 179 телевиз, 600 гаруй студи продакшн ажиллаж байгаа нь уг хөтөлбөрийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг тодорхойлж болох талтай.

[Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан](#)

Онцлог зүйл/Туршлага:

Хөтөлбөрөөр төгссөн мэргэжилтэнгүүдийн 80 хүртлэх хувь нь ажлын байртай байгаа ба зах зээлд эхлэх хувиар нийт ажил олгогчдыг ажлын байрыг мөн л 70-75 хувийг бүрдүүлж байгааг судалгаа болон ажил олгогч, төгсөгчдийн уулзалтуудаар нотолсон болно.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- [Суралцаж буй гадаад оюутны тоо](#)

Тус сургуульд өвөр Монголоос сүүлийн таван жилд нийт 43 оюутан суралцаж байна. Цаашид суралцах гадаад оюутны тоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллаж байна.

- [Олон улсын хамтарсан хөтөлбөрийн хэрэгжилт](#)
- Тус хөтөлбөр нь гадаадын мэргэжлийн олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллаж байна. Хамтарсан уран бүтээл туурвих, төсөл хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах, соёлын үйлдвэрлэлийн инкубатор төв байгуулах зэрэг ажлыг Шанхайн театр, киноны академийн дэргэдэх кино телевизийн сургууль, Бээжингийн кино урлагын сургууль болон бусад Солонгос, Польш, Япон зэрэг орнуудын кино урлагийн сургуулиудтай хамтран хийдэг. Тухайлбал энэ хамтын ажиллагааны хүрээнд 2017 онд “Кино боловсролын асуудлаар” форум зохион байгуулсан, Оюутнуудын кино бүтээх дадлагыг Шанхайн хамтын ажиллагаатай сургуультай хийж 3 богино хэмжээний кино хийсэн зэрэг хамтын ажиллагааны олон амжилтуудыг нотолсон зураг, гэрээ зэрэг нотлох баримтуудаас харсан.

Олон улсын чанартай олимпиад уралдаан тэмцээнд үзүүлсэн амжилт

- Оюутан багш нарыг гадаад, дотоодын уралдаан тэмцээнд байнга оролцуулж дэмжиж ажилладаг нь олон шагнал, байр эзэлсэн өргөмжлөл цомуудаас харагдаж байв.
- Олон улсын магадлан итгэмжлэлд итгэмжлэгдсэн дарагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчид одоогоор байхгүй байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

7.4. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- [Хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар олон нийтийг үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллээр тогтмол хангадаг байдал](#)
- Хөтөлбөр нь мэдээллийг олон нийтэд нээлттэй хүргэх талаар тусай төлөвлөгөөний дагуу ажилладаг байна. Тухайлбал хөтөлбөрийн талаарх мэдээллийг хүргэхдээ элсэлтийн өмнөх сургалт зохион байгуулах, радио телевизийн сурталчилгаа хийлгэх, телевизийн нэвтрүүлэг хийх, хөтөлбөрийн үр дүнг сурталчилсан бүтээлийн үзэсгэлэнг үе шаттай зохион байгуулах, гадаад дотоодын уралдаан тэмцээнд

оролцож гаргасан амжилтуудаа олон нийтэд системтэйгээр түгээх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнгээ тайлагнадаг байна.

- [Вебсайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа](#)
- Хөтөлбөрийн сургалтын болон бусад олон нийтийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүргэхдээ мэдээллийг өөрийн цахим хуудас/www.sbm.msuac.edu.mn/, албан ёсны фейсбүүк хуудас /www.facebook.com/sbma.msuac/, youtube суваг, uniculture удирдлагын мэдээллийн системийг ашиглан мэдээллийг хүргэдэг байна. Мэдээлэл нь чанартай, цаг хугацааны хувьд нийцсэн сайн түгээгддэг болох нь дээрх сувагт тавьсан мэдээлэл түүнийг уншсан хэрэглэгчийн тооноос харж болохоор байна..

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Шалгуур 8. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

8.1.Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээг тогтмол, давтамжтай хийдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- СУИС-ийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмыг захирлын 2012 оны 2 дугаар сарын 29-ний өдрийн А/75 тоот тушаалаар баталсан байна.
- Хөтөлбөрийн ерөнхий хороо нь хөтөлбөрт дунд болон урт хугацааны шинжилгээ хийх, үнэлэлт өгөх ажлын хийдэг байна.
- Хөтөлбөрийг тасралтгүй сайжруулах, үйл ажиллагааны механизм нь тайлангийн 243-р хуудсанд бичигдсэнээр хөтөлбөрийн оролцогч талуудын хөтөлбөрт өгөх санал шүүмжийг авч, тандан судалгаа, үнэлгээ, дотоод хяналтыг хийсний дараа өөрчлөлтийг оруулан хөтөлбөрийн дэд хороо, хөтөлбөрийн ерөнхий хороогоор дахин шинэчлэгдсэн хөтөлбөрийг батлуулах замаар эргэх холбоотой ажилладаг нь нотлогдсон. Тухайлбал, төгсөгчдөөс хөтөлбөрөөр олгосон ур чадваруудад үнэлгээ авч үнэлгээнд харьцуулалт, дүгнэлт хийж ажилласан байна.

Зураглаачийн төгсөгчдийн амжилт

1. МҮОНРТ-ийн зураглаач Ж.Нямсүх – Ази номхон далайн орнуудын ТВ-үүдийн холбооны олон улсын уралдаанд 5 удаа тэргүүн байр эзэлж байсан. “Тусгай салаа” монголын олон ангит уран сайхны киногоороо Германд болсон цэрэг эх орны сэдэвт ОУ-ын Баримтат, уран сайхны киноны наадмын “ТВ-ийн уран сайхны кино номинаци”-д тэргүүн байр эзэлсэн. Америкийн олон улсын баримтат киноны уралдаанд ажилттай оролцсон
2. МҮОНТВ-ийн зураглаачийн албаны дарга С.Отгонжаргал Ази номхон далайн орнуудын ТВ-үүдийн холбооны олон улсын уралдаанд Баримтат киногоор шилдэг бүтээлийн шагнал, МУСТА, ХМТА, РТТА
3. Ж.Эрдэнэсайхан, Г.Отгонтөгс ОХУ-д 2010 оны 8-р сард зохиогдсон “Загасан нүд” наадамд нар зураглаачаар ажиллаж “Байгаль” номинацид тэргүүн байр эзэлсэн
4. Шилдэг зураглаач шалгаруулах “Алмаз” наадамд МҮОНТ-ийн зураглаач М.Төрманлай “Гар утсаар авсан кино” төрөлд шилдэг зураглаач
5. Шилдэг зураглаач шалгаруулах “Алмаз” наадамд “Уран сайхны кино” номинацид Лимон студийн зураглаач Л.Лхагвадорж “Ээж бид хоёр” шилдэг зураглаач
6. Шилдэг зураглаач шалгаруулах “Алмаз” наадамд “Шилдэг мэдээ сурвалжлага” номинацид UBS телевизийн зураглаач М.Цогтбаяр шилдэг зураглаач
7. Д.Давааням “Азийн шилдэг гэрэл зурагчин” 2017 он, 2009 онд зохиогдсон “Анхны бүтээл” уран бүтээлийн наадамд “Хэрлэн гол” зураглалаар тэргүүн байр, “Бүү март 7 сарын 1” зураглалаар Гранпри шагнал
8. Зураглаач Л.Дашдооров “48 цаг Монголд” 2017 оны наадамд шилдэг, Франфад болсон кино наадамд шилдэг “Зураг авалт”, Канын кино наадмын шилдэг Богино хэмжээний кино бүтээлд өрсөлдөх эрх авсан.
9. UBS телевизийн зураглаач Г.Алтаншагай ХМТА
10. UBS телевизийн зураглаач М.Цогтбаяр МУСТА
11. UBS телевизийн зураглаач М.Батзаяа МУСТА
12. ТВ9 Зураглаач Орломжав СТА, ХМТА
13. Б.Батмөнх “Алтангадас”
14. Зураглаач М.Төрманлай РТТА
15. МҮОТВ-ийн зураглаач Ч.Төгс РТТА
16. МҮОНТВ-ийн зураглаач Б.Өгөөдэй РТТА
17. UBS телевизийн зураглаач Х.Баатар ХМТА
18. ТВ5 телевизийн зураглаач Х.Эрдэнэбат телевизүүдийн холбооны шилдэг зураглаач “Алтан шонхор” шагнал
19. ТЕГ-ын ХМА Г.Дүгэржав МУСТ, Цэргийн гавьяаны одон, ХМТА
20. Аист телевизийн зураглаач Ж.Отгонбат ОХУ-ын Буриад улсын телевизүүдийн шагнал
21. ТВ4 телевизийн уран сайхны удирдагч Д.Энхтөр МУСТА, ХМТА
22. Баянхонгор аймгийн төв теледизийн зураглаач Б.Анхбаяр МУСТА
23. МНС телевизийн зураглаачдын албаны дарга Ү.Алтанбагана МУСТА, ХМТА
24. “Оргил” ХХК-ийн ХМА-ны дарга Г.Тэмүүжин ХМТА, ЭМТА

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

8-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан.

ДҮГНЭЛТ:

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
	Шалгуур 1	3	-	-	
2	Шалгуур 2	3	-	-	
3	Шалгуур 3	6	-	-	
4	Шалгуур 4	5	-	-	
5	Шалгуур 5	3	1	-	
6	Шалгуур 6	3	-	-	
7	Шалгуур 7	2	1	-	
8	Шалгуур 8	1	-	-	
Дүгнэлт		Баримт материал, нотлох баримт, сургуулийн орчин анги танхим, тоног төхөөрөмж, суралцах орчин, төгсөгчид, ажил олгогчид, багш нарын уулзалт, ярилцлага дээр үндэслэн Радио, телевиз медиа урлагийн сургуулийн “Зураг авалт” /021101/ бакалаврын хөтөлбөрыг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “Шалгуурыг бүрэн хангасан” гэж дүгнэж байна.			

ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН ЭЦСИЙН ДҮГНЭЛТ:

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг СУИС-ийн Радио, телевиз, медиа урлагийн сургуулийн “Зураг авалт” бакалаврын сургалтын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна. Шинжээчийн багийн дүгнэлтийг Урлаг, хүмүүнлэгийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг/Р.Чанцалдулам/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг/Д.Чулуунгэрэл/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Г.Түвдэндорж/

V. Оролцогчдын нэрс

I. Ярилцлагад оролцсон багш нарын нэрс.

203 тоот

2018.05.04

№	Овог нэр	Салбар	Тэнхим	Албан тушаал
1	Ц.Туяа	РТМУС	КТТ	Багш
2	Г.Оюунчимэг	РТМУС	КТТ	Багш
3	Ч.Отгонбаяр	РТМУС	КТТ	Багш
4	Д.Хишигт	РТМУС	КТТ	Багш
5	М.Батзориг	РТМУС	Медиа анимэйшн	Багш
6	Г.Болор	РТМУС	Дуун техник технологийн тэнхим	Т/Эрхлэгч
7	Ч.Болд-Эрдэнэ	РТМУС	Медиа анимэйшн	Багш
8	О.Өсөхбаяр	РТМУС	Медиа анимэйшн	Багш
9	С.Дэлгэрмаа	РТМУС	Сэтгүүл зүй	Т/эрхлэгч
10	Д.Бүүсүрэн	РТМУС	Дуун техник технологийн тэнхим	Багш
11	Д.Давааням	РТМУС	КТТ	Багш
12	Б.Донров	РТМУС	Зураглаач	Багш

II. Ярилцлагад оролцсон Оюутны нэрс

203 тоот

2018-05-04

№	Овог нэр	Салбар	Хөтөлбөр, мэргэшил	Курс, түвшин
1	Б.Батмөнх	СУИС, РТМУС	Зураглаач	3-р курс
2	Л.Нямцэрэн	СУИС, РТМУС	Зураглаач	3-р курс
3	А.Баянсан	СУИС, РТМУС	Зураглаач	4-р курс
4	Д.Батням	СУИС, РТМУС	Зураглаач	4-р курс
5	Э.Алтангэрэл	СУИС, РТМУС	Зураглаач	4-р курс
6	А.Билгүүн	СУИС, РТМУС	Зураглаач	4-р курс
7	Б.Нямсүрэн	СУИС, РТМУС	Зураглаач	4-р курс
8	Г.Санжааноров	СУИС, РТМУС	Зураглаач	1-р курс
9	Б.Мөнхсүрэн	СУИС, РТМУС	Зураглаач	1-р курс
10	Ц.Буянхүү	СУИС, РТМУС	Зураглаач	1-р курс
11	Х.Номиндарь	СУИС, РТМУС	Зураглаач	3-р курс
12	А.Ариунмөнх	СУИС, РТМУС	Зураглаач	3-р курс
13	Б.Биндэрьяа	СУИС, РТМУС	Зураглаач	3-р курс
14	Э.Тэмүүжин	СУИС, РТМУС	Зураглаач	3-р курс
15	Э.Есөнжин	СУИС, РТМУС	Зураглаач	3-р курс
16	О.Энхтөр	СУИС, РТМУС	Зураглаач	3-р курс
17	О.Болорсүвд	СУИС, РТМУС	Зураглаач	3-р курс
18	Э.Улсболд	СУИС, РТМУС	Зураглаач	3-р курс
19	Б.Галбадрах	СУИС, РТМУС	Зураглаач	4-р курс
20	А.Бат-Орших	СУИС, РТМУС	Зураглаач	4-р курс

III. Ярилцлагад оролцсон Ажил олгогчийн нэрс

№	Овог нэр	Албан газар	Албан тушаал	Ажил олгодог салбар мэргэжил
1	Ц.Тайван	ГХЯ	Ахлах мэргэжилтэн	Төрийн байгууллага
2	Г.Дүгэржав	ТЕГ	Ахлах ажилтан	Төрийн байгууллага
3	Ч.Алтанбагана	“MNC” TV	Ахлах зураглаач	TV
4	С.Отгонжаргал	МҮОНТ	Албаны дарга	Төрийн
5	Н.Батбаяр	ETV	Зураглаач	TV
6	Г.Тэмүүжин	Оргил рашаан сувилал	Мэргэжилтэн	ТББ
7	Д.Батбаяр	МҮОНТ	Продюссер	Төрийн

IV. Ярилцлагад оролцсон төгсөгчдийн нэрс

№	Овог нэр	Төгссөн он	Хөтөлбөр, мэргэшил	Ажил, албан тушаал
1	Ц.Шинэбаяр	2006	Телевизийн сэтгүүлч	Eagle TV
2	Б.Долгорсүрэн	2006	Телевизийн зураглаач	МҮОНТ
3	Г.Алтаншагай	2011	Кино телевизийн зураглаач	UBSTV
4	Б.Өгөөдэй	2012	Кино TV-ийн зураглаач	MNB
5	Б.Гийгүүлэн	2012	Кино TV-ийн зураглаач	Чөлөөт уран бүтээлч
6	Ганбаатар	2016	Кино TV-ийн зураглаач	РТМУС

VI. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

/албан бичгийг оруулах/

Хавсралт

Зөвлөмж /Recommendations/

Ажил олгогчийн уулзалтын дүгнэлт:

- **Нэг. Төгсөгчийн хувьд мэргэжилдээ өгөх үнэлгээ**
 - Багш нарын хувьд хамгийн чадварлаг туршлагатай багш нар байдаг.
 - Багш нарын хоорондын хичээл хоорондын уялдааг сайн хангаж ажилладаг.
 - Сургуулийн суралцах боломж нь сайн болсон.
- **Төгсөгчийн мэдлэг, үр чадварын давуу тал**
 - Төгсөгчдийг мэргэшүүлэх шаардлагатай байдаг.
 - Ижил мэргэжлийн бусад сургуулийн оюутнуудтай харьцуулахад арай илүү байдаг. Тухайлбал план тавих, зургийг харах өнцгийг харах чадамж зэрэг нь илүү байдаг.
 - МҮОНТ-ийн зураг авалтын төгсөгчдийн 80 орчим хувь нь энэ сургуулийг төгссөн хүүхдүүд байдаг. Хандлага нь зөв төлөвшсөн байдаг.
 - Төгсөгчдийн онолын хувьд өргөн мэдлэгтэй болж байгаа. Олон талын мэдлэг их шаарддаг.
 - Дадлага их авах боломжтой байдаг. Тиймээс техник төхөөрөмжтэй ажиллах чадвар нь давуу талтай байдаг.
 - Ерөнхий мэдлэг нь муу байдаг. Ялангуяа үүнийг анхаарах шаардлагатай байдаг.
 - Зураг авалтын хөтөлбөрөөр төгсөгчийн хувьд салбар шинжлэх ухааны хувьд харж чаддаг хувь хүний чадвар сайн байх шаардлагатай байдаг.
 - Зураг авалтын монтаж хийх чадвар нь сайн төгсөж байна.
 - Дадлага хийх хугацаанд нь ажилд авах боломж их бүрддэг байна.
 - Ажилд авахдаа төгсөгчийн суурь хүмүүжил, хандлагыг нь илүү хардаг.
 - Зураглаачийн хувьд хөрвөх чадвар нь сайн байдаг.
 - Энэ мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудыг төгсөх ангиас нь багш нартай ярилцаж байгаад дадлагажуулж авдаг.
 - Олон улсын тэмцээнд оролцож шагнал авдаг нь сургалт сайн давуу талтай байгааг харуулж байна.
 - Ажлын байранд шууд ордогоороо давуу талтай.
- **Төгсөгчдийн мэдлэг, үр чадвар дутагдалтай тал**
 - Ачаалал даах чадвар сэтгэл зүйн хувьд төлөвшүүлэх шаардлагатай.
 - Салбар дундын мэдлэг их шаардагддаг. Энэ талаар анхаарах шаардлагатай.
- **Хөтөлбөрөөр олгох мэдлэг, үр чадварт өгөх цаашид зөвлөмж:**
 - Мэргэшсэн чиглэлээр ялангуяа салбар дундын мэргэжлийн мэдлэг, эзэмшүүлэх нь давуу тал болно гэж үзэж байна.
 - Зураглаач мэргэжилтэн нь мэдээ бичих, эвлүүлэг хийх, чадвартай байх шаардлагатай байдаг. Тиймээс илүү сайн хөрвөх чадвартай болгох нь ажлын байраар хангагдах боломж нь илүү байх болно.

- **Төгсөгчдийн уулзалтын дүгнэлтүүд:**
 - **Нэг. хичээлийн агуулгын хувьд:**
 - Мэргэжлийн хувьд зураглаач нь сэтгүүлчийн үүргийг хамтад нь хийх тохиолдол гардаг тиймээс энэ мэргэжил нь давуу талтай байдаг.
 - Телевизийн хувьд олон ур чадвар шаарддаг хөрвөх чадвар сайн байдаг.
 - Орчин үеийн технологитой уялдаж өнгийн шинжлэх ухааны хичээлийг илүү дэлгэрэнгүй орвол зүгээр байна. Ялангуяа технологийн хувьд хоцрогдоогүй байгаа нь харагдаж байна.
 - Суурь чадвараа сайн авсан болохоор хөрвөх чадвар сайн байдаг.
 - Оюутны дадлага, бүтээл хийх боломжоор сайн хангадаг, ялангуяа дадлагажих боломж нь сайн байсан.
 - Олон талаас харах мэдрэмж, хурдтай байх чадварыг нь хараад мэргэшүүлэх чиглэлэд нь зөвлөгөө илүү сайн өгдөн байвал сайн байна.
 - Хэлийг сайн сурах хэрэгтэй баймаар байна гэж суралцаж байгаа дүү нартаа хэлмээр байна.
 - **Хоёр. Сэтгэл ханамж, төгсөгчдийн эргэх холбоо**
 - Мэргэжлээрээ сайн амжилтай ажиллаж байгаа болохоор сэтгэл ханамж өндөр байдаг.
 - Төгсөгчдийн холбоонд ажиллаж байсан хамтдаа спортын тэмцээн болдог.
 - Төгсөлтийн дараах сургалтыг сайн зохион байгуулах, оюутнуудтай уулзалт зохион байгуулах нь хэрэгтэй санагддаг.
 - **Гурав. Давуу тал**
 - Практик мэдлэг сайтай байдаг. Манай төгсөгчдийн 80 орчим хувь нь мэргэжлээрээ ажилладаг.
 - Оюутан байхаасаа телевизүүдэд ажиллаж эхэлдэг энэ нь илүү их ур чадвар олгодог.
 - Багш нар ур чадварын хувьд хамгийн мундаг зураглаач багш нар байдаг. Энэ багш нараасаа олон зүйл сурсан. Багш нарын хувьд телевизийн болон киноны гэсэн мэргэшсэн багш нар олон байдаг.

Дутагдалтай тал:

- Ажлын цаг их байдаг болохоор мэргэжлийн хувьд ахисан түвшинд суралцах цаг хугацаа бага байдаг.